

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

---

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

## **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-22
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	23-65

---

1.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 23-27

2.Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал 27-28

3.“Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/ 28-65

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 20-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 00 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Г.Лувсанжамц,  
Б.Мөнхсоёл, Л.Соронзонболд, Л.Энх-Амгалан;  
Чөлөөтэй: Ж.Золжаргал, М.Мандхай, О.Цогтгэрэл;  
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Одбаяр, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат;  
Тасалсан: Б.Пунсалмаа.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаар асуудал буюу “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5-д “Энэ хуулийн 31.1, 31.2, 31.4-т заасан этгээд төслийн хэлэлцүүлгийн бүх үе шатанд оролцох үүрэгтэй ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бол тухайн асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулна.” гэж заасны дагуу хойшлуулж байгаа талаар танилцуулав.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл хэлэлцэх асуудлын дарааллын 5 дугаар асуудал буюу бусад асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт оруулж хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 5 дугаар асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт оруулж хэлэлцэхээр тогтов.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар хэлэлцэх асуудлын дарааллын 4 дүгээр асуудал буюу Мэдээллийн

технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх асуудлыг асуулга асуусан Улсын Их Хурлын гишүүд томилолттой байгаа тул хэлэлцэх асуудлын дарааллаас хасъя гэсэн горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	1
Бүгд:	18

94.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын дарааллаас хасав.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу хэлэлцэх асуудлын дарааллын 5 дугаар асуудал буюу бусад асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт оруулж хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	6
Бүгд:	18

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 5 дугаар асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт оруулж хэлэлцэхээр тогтов.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг хэлэлцэх асуудлын дараалалд орсон 5 асуудлаас 2 асуудал хасагдсан тул үлдсэн 3 асуудлыг хэлэлцэх асуудлын батлагдсан тов, дарааралд орсон дарааллаар хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	12
Бүгд:	18

33.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан, хэлэлцэх асуудлын дарааллын 5 дугаар асуудал буюу бусад асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт оруулж хэлэлцүүлж гэсэн горимын саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн тайлбар хийв.

*Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Ч.Лодойсамбуу нарын гаргасан горимын саналуудаар дахин санал хураалт явуулав.*

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 11  
Бүгд: 18  
38.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн дахин санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 4  
Бүгд: 18  
77.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 5 дугаар асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт буюу батлагдсан тов, дарааллын дагуу хэлэлцэхээр тогтов.

***Нэг.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Төв тусгал” сургалт, судалгааны төвийн судлаач Э.Сундуй, “Өмгөөллийн Грандлекс партнерс” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн өмгөөлөгч Ж.Дамбаасүрэн, Монголын хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Д.Болд-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн санал хэлэв.

*Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 2  
Бүгд: 18  
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Хоёр.Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хуралд дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Н.Батсүмбэрэл Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалыг нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабалыг Эдийн засгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 3  
Бүгд: 18  
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхланг дэмжсэнээр тооцож, 88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. “Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Б.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлогын газрын дарга Б.Бат-Өлзий, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Энхтөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын дарга Т.Гантогтох, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмацэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж, ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн дэд ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Ц.Баатархүү нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

*“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

#### **Нэг.Тогтоолын төсөлд ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал:**

**Р.Сэддорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Н.Наранбаатар, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, П.Ганзориг, Т.Мөнхсайхан, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара, Г.Очирбат, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ч.Ундрэм, Г.Уянгахишиг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх;

“3/Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд үзүүлэх нөлөөллийг хэмжих аргачлал, үнэлгээний үзүүлэлтийг боловсруулж, 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалыг дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх;

“4/“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-ийг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөө болон улсын төсвийн төслийг боловсруулахдаа бүрэн тусгасан байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Хоёр.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал:**

**Р.Сэддорж:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

“Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотод Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулж бүс нутгийн түвшинд хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт манлайлан, хүний эрхийн салбарын хамтын нийгэмлэг, үндэсний хүний эрхийн байгууллагууд (NHRI), иргэний нийгэм, эрдэм шинжилгээ, судалгааны зангилаа төв болон хөгжиж, аялал жуулчлал шинэ урсгалыг бий болгож, эерэг үр дүн гарна.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Гурав.Тогтоолын төслийн 2 дугаар Хавсралтад ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал:**

1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга 1.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтын Хөтөлбөрийн үр дүн “Стандартын шаардлага хангасан орчинтой, эрчим хүчний хэмнэлттэй дулаан алдагдал багатай барилга бүхий цэцэрлэгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.” гэж өөрчлөн найруулах.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтын Хөтөлбөрийн үр дүн “Стандартын шаардлага хангасан орчинтой, эрчим хүчний хэмнэлттэй дулаан алдагдал багатай барилга бүхий Ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ гэж өөрчлөн найруулах гэсэн 1, 2 дугаар саналуудаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

**Р.Сэддорж:** 3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.2 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээ “Хиймэл оюун ухааны программ хангамжийн нэмэлт сайжруулалт хийх” гэснийг “Хиймэл оюун ухааны тоног төхөөрөмжийн нэмэлт сайжруулалт” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.1.3, МУШЭМХББ-3, МУХТЖҮЧ-5.1” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “0” гэснийг “3,700.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “0” гэснийг 1,500.0” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	9
Бүгд:	18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	8
Бүгд:	18

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Р.Сэддорж:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	8
Бүгд:	18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**Р.Сэддорж:** 4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “10.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.4.1, 2.4.2, 2.4.3, 2.4.4, МУХТЖҮЧ-10.1.1.1, ЗГҮАХ-3.3.7.1, 3.3.7.3, 3.3.7.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Малын эрүүл мэндийн дэвшилтэт технологийн үйлдвэр байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “10,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “300.0” гэж,

Санхүүжилтийн эх үүсвэр “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	9
Бүгд:	18

50.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 10.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.4.1, 2.4.2, 2.4.3, 2.4.4, 2.4.6, МУХТЖҮЧ-10.1.1.1, ЗГҮАХ-3.3.7.1, 3.3.7.3, 3.3.7.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Малын эрүүл мэндийн дэвшилтэт технологийн үйлдвэр байгуулах (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “7,027.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,514.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	8
Бүгд:	18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтын “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Хүрэн нүүрснээс хагас кокс эрчим хүч үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээг бүхэлд нь хасах гэсэн саналаар санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв нар тайлбар хийв.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-6.4.7, 6.4.9, 6.4.11, 6.4.16, МУХТЖҮЧ-6.2.1.1, ЗГҮАХ-3.4.2.1, 3.4.2.2”, Төсөл, арга хэмжээ “Айл өрхийн сууцны дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй халаалт, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжид зориулсан ногоон зээлийн хүүгийн татаас олгох” гэж, Шалгуур үзүүлэлт “Дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй шийдэл нэвтрүүлсэн айл өрхийн тоо” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “5,000” гэж, Зорилтот түвшин “38,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “300,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилтэд сая.төг “100,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	7
Бүгд:	18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, ажлын хэсгийн дэд ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат нар тайлбар хийв.

8.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.8 “Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ.” гэснийг “1.2.1.8. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг тогтмолжуулна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.3, МУХТЖҮЧ-1.2.1.8, ЗГҮАХ-2.3.1.1” гэснийг “АХ-2.2.3, 2.2.5, МУХТЖҮЧ-1.2.1.1, 1.2.1.8, ЗГҮАХ-2.2.1, 2.3.1.1” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	7
Бүгд:	18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.1 дэх дэд заалт “1.2.1.1.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах эмнэлэг, эрүүл мэндийн барилгуудыг үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах” гэснийг “1.2.1.1.1.Аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах” гэж, Зорилтот түвшин “100” гэснийг “20” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	9
Бүгд:	18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЕЗ/ хөтөлбөрийн нэр “71804 Мэргэжлийн боловсрол”, Үр дүн “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” гэж, Шалгуур үзүүлэлт “Багшийн үндсэн цалин (Улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно)” гэж, Тогтвортой хөгжлийн зорилго “4.с.1” гэж, Хэмжих нэгж “Индекс” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “2,726.9” гэж, Зорилтот түвшин-2027 “2026 оны түвшнээс дээгүүр” гэж, Мэдээллийн эх сурвалж “Үндэсний статистикийн хороо, боловсролын яам” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “Жил тутам” гэж, Хариуцах байгууллага “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	9
Бүгд:	18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЕЗ/ хөтөлбөрийн нэр “71801 Сургуулийн өмнөх боловсрол”, Үр дүн “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” үр дүнгийн хүрээнд Шалгуур үзүүлэлт “Багшийн үндсэн цалин (Улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно)” гэж,

Тогтвортой хөгжлийн зорилго “4.с.1” гэж, Хэмжих нэгж “Индекс” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “2,726.9” гэж, Зорилтот түвшин-2027 “2026 оны түвшнээс дээгүүр” гэж, Мэдээллийн эх сурвалж “Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “Жил тутам” гэж, Хариуцах байгууллага “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир тайлбар хийв.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЭЗ/хөтөлбөрийн нэр “71802 Ерөнхий боловсрол”, Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” гэсэн үр дүнгийн Суурь түвшин “1484” гэснийг “2769.9” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.27”, “МУХТЖҮЧ-2.2.12”, “ЗГҮАХ-2.3.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Бүсийн оношилгоо эмчилгээний төвд MRI оношилгооны тоног төхөөрөмж (Дорнод, Хэрлэн) гэж, Шалгуур үзүүлэлт “Стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмж” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “1” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,120.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,120.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 11

Бүгд: 18

38.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр тайлбар хийв.

14.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.2, 3.2.1, 8.3.6, 4.4.1.3”, “ЗГҮАХ-3.4.11” гэж, Төсөл, арга хэмжээ “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах /Дорнод аймгийн Хөлөнбуйр сум/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,850.1” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “925.1” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн

хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа нар хариулж, тайлбар хийв.

15.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.3”, “МУХТЖҮЧ-4.4.1”, “ЗГҮАХ-2.4.3.3” гэж, Төсөл, арга хэмжээ “1000 айлын орон сууцны хороолол”-ын гадна ус хангамж, ариутгах татуурга, гадна холбоо (Дорнод, Хэрлэн сум) гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,790.6” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,895.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” Хамтран хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 10  
Бүгд: 18  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.35”, “МУХТЖҮЧ-5.6.1.1”, “ЗГҮАХ-3.3.3.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Буйр нуур орчмын цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх (Дорнод, Халхгол сум) гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “978.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “978.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.3.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.3, 8.3.6”, “МУХТЖҮЧ-5.3.1.3”, “ЗГҮАХ-3.4.11” гэж, Төсөл, арга хэмжээ “Үр тарианы элеваторын барилга (Дорнод, Хэрлэн сум) гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч

“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.35”, “МУХТЖҮЧ-5.6.1.1”, “ЗГҮАХ-3.3.3.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Хавирга хилийн боомтын өргөтгөлийн цахилгаан хангамж Хавирга 35 Кв ЦДАШ, 35/10 кВ-ын 2\*1600 Ква чадлын “Хавирга” дэд станц 35/10 кВ-ын “Хэрлэн” дэд станцын өргөтгөл (Дорнод) гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “10,402.7” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “5,201.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 10  
Бүгд: 18  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

19.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 8.1.2.5 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.45”, “МУХТЖҮЧ-5.4.1.2”, “ЗГҮАХ-3.3.5.9, 3.3.5.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Түүхэн аялал жуулчлалын хүрээнд “Чингис хааны Тугийн сүм” цогцолбор байгуулах (Дорнод, Булган сум)” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,900.2” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “950.1” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 10  
Бүгд: 18  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

20.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Малчин сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “13,316.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,438.7” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Б.Заяабал нарын тавьсан асуултад Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал хариулж, тайлбар хийв.

21.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.4, МУХТЖҮЧ-1.2.1.1, ЗГҮАХ-1.4.2.5, 2.3.1.1, 2.3.1.2, 2.3.1.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрүүл мэндийн төвийн барилга /Увс, Хяргас сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,350.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,116.7” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2, 6.4, МУХТЖҮЧ-4.4.1.2, ЗГҮАХ-2.4.3.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаангом сум доторх инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл хийх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “125,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “12,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 10  
Бүгд: 18  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

23.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.2, ЗГҮАХ-3.3.2.24” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаангом-Наранбулаг чиглэлийн авто замаас Хар толгой-Тариалан сум чиглэлийн 20.7 км хатуу хучилттай авто зам /Увс, Тариалан сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “20” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “30,940.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,188.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 11  
Бүгд: 18

38.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

24.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-1.3.3.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай 92.13 км авто зам барих /Орхон, Дархан-Уул, Төв/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “150,034.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “11,139.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээнд “Жаргалант-Шинэ-Идэр-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “323,196.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “96,958.80” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 12  
Бүгд: 18

33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

26.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “6.3.1.2 дахь дэд заалтын “Онги-Цагаанбургастай” төслийн бэлэн байдлын хангалт” гэсэн Шалгуур үзүүлэлтийн “Нийт санхүүжилтийн дүн сая төгрөг “0” гэснийг “44,490.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “0” гэснийг “30,230.0” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат 17 цаг 51 минутаас 17 цаг 56 минутад Байнгын хорооны хуралдааныг даргалав.

**Г.Очирбат:** 27.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “5.7.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.2, ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замаас Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн авто замын их засварын ажил” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “15,054.685” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “15,054.685” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	14
Бүгд:	18

22.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

28.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “4.4.4.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.3, МУХТЖҮЧ-4.4.4.1, ЗГҮАХ-1.1.4.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Төв аймгийн Баянчандмань сумын Дархан-Эрдэнэтийн зам дээр гүүрэн зам тавих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, “Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,100.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,100.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	12
Бүгд:	18

33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

29.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1”, “МУХТЖҮЧ-5.7.1.1”, “ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 87.9 км” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “45” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “92.31 тэрбум төгрөг” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “92.31 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	10
Бүгд:	18

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Р.Сэддорж:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Р.Сэддорж:** 30.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1”, “МУХТЖҮЧ-5.7.1.1”, “ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Чойр-Мандалговь-Арвайхээрийн чиглэлийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “230.98 тэрбум төгрөг” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “105.0 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.39”, “МУХТЖҮЧ-5.6.1.3”, “ЗГҮАХ-1.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Дорноговь аймгийн Айраг сумын 8 МВт хүчин чадалтай дулааны зуух барих, шугам сүлжээ өргөтгөх” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “8,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “8,800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 10  
Бүгд: 18  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

32.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.3.3 дахь дэд заалтын “Гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах ажиллагаанд хүнгүй техник хэрэгслийг нэвтрүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээний Суурь он “2025” гэснийг “2024” гэж, Суурь түвшин “102” гэснийг “10” гэж, Зорилтот түвшин “112” гэснийг “20” гэж,

Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,650.0” гэснийг “3,300.0” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.14”, “МУХТЖҮЧ-5.1.1.1”, “ЗГҮАХ-3.3.1.13” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр” гэж, Шалгуур үзүүлэлт “Нүүрснээс үйлдвэрлэх шатахуун, хийн түлшний дотоодын хэрэглээнд эзлэх хувь хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “75,645.70” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,564.57” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 10  
Бүгд: 18  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

34.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.8”, “МУХТЖҮЧ-6.2.2.1”, “ЗГҮАХ-3.3.3.6, 3.3.3.9, 3.3.3.12” гэж, Төсөл, арга хэмжээ “10,000 нарны дээвэр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хөтөлбөрт хамрагдсан өрх” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “3000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “298,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “89,400.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагч “Эрчим хүчний зохицуулах хороо” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат санал хэлэв.

35.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.6.1.дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “Хүний эрхийн боловсрол, судалгаа шинжилгээний бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.5, 5.1.8”, “МУХТЖҮЧ-7.6.1”, “ЗГҮАХ-4.1.1.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “900.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “900.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гадаад харилцааны

яам” гэж, Хамтран хариуцагч “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.26, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “6-9 дүгээр ангийн нийт 263808 хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулах /хичээллэх хоног 180, нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 3500₮/” гэж, Шалгуур үзүүлэлт “6-9 дүгээр ангийн сурагчдын үдийн хоолонд хамрагдалт” Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “228,300.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “228,300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Д.Үүрийнтуяа, П.Батчимэг нарын тавьсан асуултад Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир хариулж, тайлбар хийв.

37.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.14, 2.1.26, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад шим тэжээллэг хоолны үйлчилгээг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Дунд ангийн /6-9 дүгээр анги/ нэг суралцагчийн сургуулийн хоолны үйлчилгээний санхүүжилтийн хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Төгрөг” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “4000 төгрөг” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “191,152.8” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “191,152.8” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх гэсэн санал нь 36 дахь саналд багтсан байгаа тул санал хураалт явуулаагүй болно.

38.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.26, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “10-12 дугаар ангийн нийт 134491 хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулах /хичээллэх хоног 185, нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 4000₮/” гэж, Шалгуур үзүүлэлт “10-12 дугаар ангийн сурагчдын үдийн хоолонд хамрагдалт” Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “128,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “128,800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч

“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын “5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.10”, “МУХТЖҮЧ-1.1.2.1”, “ЗГҮАХ-2.2.2.1.4, 2.2.2.1.” гэж, Төсөл, арга хэмжээ “Сурагчийн 59 дүгээр гудамжнаас 47 дугаар гудамж хуртэлх авто зам, гүүрний ажил авто замын их засварын ажил” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “6” гэж, Зорилтот түвшин “8” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,650.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,650.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.13, МУХТЖҮЧ-6.3.1.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Сургалтын STEAM боловсролын хэрэглэгдэхүүн” гэж, Шалгуур үзүүлэлт “Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “16” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир тайлбар хийв.

41.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.37, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Чингэлтэй дүүргийн нэг сургуулийг Кембрижийн хөтөлбөртэй болгох” гэж, Шалгуур үзүүлэлт Стандартын техник зохицуулалтын шаардлага хангасан ерөнхий боловсролын эзлэх хувь, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “4” гэж, Зорилтот түвшин “6” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

**Р.Сэддорж:** 42.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.3.3, МУХТЖҮЧ-2.1.4.1, ЗГҮАХ-2.1.3.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Чингэлтэй дүүргийн ЖДҮ үйлдвэрлэл эрхлэгч нарт тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хамрагдсан өрх,” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “1259” Зорилтот түвшин “3000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

43.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.3 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2, МУХЖТЖҮЧ-1.2.1.1, ЗГҮАХ-2.3.1.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Чингэлтэй дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хорт хавдрын эрт илрүүлэг, үзлэгт хамрагдсан хүн ам” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “65” гэж, Зорилтот түвшин “66.5” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны гишүүдийн ирц хангалтгүй байгаа тул хуралдааныг 2026 оны 05 дугаар сарын 21-ний 09 цаг 00 минут хүртэл түр хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 37 минут үргэлжилж, 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 37 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхимд 15 цаг 00 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Р.Сэддорж:** Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Ренчиндоржийн Батболд, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвийн Батчимэг, Жамбалын Ганбаатар, Болдын Жавхлан, Батбаярын Жаргалан, Батжаргалын Заяабал, Чулуунбилигийн Лодойсамбуу, Загджавын Мэндсайхан, Ганбатын Очирбат, Ренчинбямбын Сэддорж, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Гончигдоржийн Уянхишиг, Саруулсайханы Цэнгүүн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна аа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг,

2.“Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж нарын 42 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх,

3.“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг,

4.Монгол Улсын Их Хурлын гишүүн Золжаргал, Анар, Мөнхбат, Соронзонболд, Галбадрах нарын 5 гишүүнээс Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын гэр Ерөнхий сайдад хандсан асуулгын хариу,

5.Бусад гэсэн ийм 5 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгье. Лодойсамбуу гишүүнээр тасалъя.

Хоёрдугаар асуудал буюу “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр 31.5 Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31.5 дээр энэ хуулийн 31.1, 31.2, 31.4-д заасан этгээд төслийн хэлэлцүүлгийн бүх үе шатад оролцох үүрэгтэй ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бол тухайн асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулна гэж заасан байгаа. Энэ асуудал дээр тодорхой байгууллагуудаас хариу авах шаардлагатай байгаа. Төсөл санаачлагч одоо өөрөө ийм хүсэлт гаргасан.

Ингээд энэ хуулийн дагуу 2 дугаар асуудлыг өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасаж байна. Одоо ингээд Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл гишүүн саналаа хэлье.

**Н.Батсүмбэрэл:** Мэнд хүргэе ээ.

Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцэх асуудлаас одоо сүүлд байгаа бусад асуудал буюу Эдийн засгийн байнгын хорооны даргын асуудлыг ярих учиртай.

Тэгээд энэ асуудлыг 1 дүгээр асуудал болгож хэлэлцэх горимын саналыг оруулж байна аа.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Анар.

**Ч.Анар:** Их Хурлын гишүүн Золжаргал, Анар, Мөнхбат, Соронзонболд, Галбадрах нараас Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариулт буюу хэлэлцэх асуудлын 5-ыг Их Хурлын гишүүд томилолттой явж байгаа тул хойшлуулж өгөх горимын санал гаргаж байна аа.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу.

**Ч.Лодойсамбуу:** Байнгын хороодын гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Энэ сая Батсүмбэрэл гишүүний гаргасан горимын саналтай холбоотойгоор 5 дугаар асуудал буюу бусад асуудлыг 1 дүгээр асуудал дээр оруулж ирье гэдэг горимын санал байгаа. Энийг би 2 дугаар асуудал болгоод, 1 дүгээр асуудал буюу одоо энэ БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг байранд нь байлгаж хэлэлцэж санал хураагаад араас нь бусад асуудал буюу одоо Байнгын хорооны даргаа шийдээд явъя гэж. Ер нь бол Байнгын хорооны дарга солигдох гэж байгаа. Байнгын хорооны даргыг бол дэмжиж байгаа. Заяабал даргыг бол дэмжиж ажиллана, дэмжиж бас саналаа өгнө.

Тийм учраас МАН-ын бүлгийн гишүүдийг бас энэ манай бүлгээс бүлгийн гишүүний өргөн барьсан энэ хуулийг бас дэмжиж саналаа өгөөд энэ санал хураалтын араас Байнгын хорооныхоо даргыг бас бүгдээрээ дэмжээд ингээд явцгаая гэсэн горимын саналтай байна.

**Р.Сэддорж:** Ингээд үндсэндээ одоо санал хураалтаар яаж шийдэхийг мэдэхгүй байна. Үндсэндээ ингээд 2, 3 асуудал болчихлоо 5 асуудлаас. Тэгэхээр зүгээр зохимж нь ямар вэ? Бусад асуудлыг 1 дүгээрт оруулчихлаа. Ингээд одоо шийдвэр гаргаад энэ чинь ингээд хэвлэл мэдээллээр яваад тэгэнгүүт чинь одоо

нөгөө хамгийн урт удаан хэлэлцэх асуудал чинь бид нар бүгдээрээ байж санал өгөх асуудал чинь бол 2027 оны Улсын хөгжлийн төлөвлөгөө байгаа шүү дээ. Энэ дээр чинь одоо нөгөө эхлээд нөгөө асуудал шийдэгдчихээд байдаг. Гэтэл одоо хүн хурал удирдаад байдаг. Энэ одоо жоохон нийгэмд зохимжгүй юм биш үү л гэсэн бодолтой байна.

Батчимэг гишүүн. Батчимэг гишүүний микрофоныг нээе.

**П.Батчимэг:** Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Тэр байнгын хорооны дарга шинээр томилогдох, нэр дэвших томилогдох гэдэг бол тусдаа асуудал байгаа. Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хурлаар хэлэлцэх ёстой асуудлуудын дарааллыг өөрчлөхгүйгээр бүх асуудлуудаа эхлээд гишүүд асуудлаа хэлэлцэж явчхаад бусад гэдэг асуудлаа хамгийн сүүлд нь хэлэлцвэл зүгээр байх гэсэн санал гаргаж байна. Саналтай байна.

**Р.Сэддорж:** Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой горимын саналаар санал хураалт явуулъя.

Нэгдүгээр санал. Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэлийн гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье.

Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрлэлийн гаргасан горимын саналаар бусад гэснийг 1 дүгээрт оруулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Улсын Их Хурлын гишүүн Анар гишүүний гаргасан горимын саналаар санал хурааа.

Дөрөвдүгээр асуудлыг хойшлуулъя гэсэн горимын санал гаргасан. Санал хураалт.

94.4 хувийн саналаар Анар гишүүний санал дэмжигдэж 4 дүгээр асуудал хойшлогдлоо.

Өнөөдрийн хуралдаанаас хойшлогдлоо.

Дараа нь Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуугийн гаргасан саналаар 1 дүгээр асуудлыг нэг дээр нь байлгая, бусад асуудлыг 2-т оруулъя гэсэн. Энэ саналаар санал хураалт явуулъя. 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Батчимэг гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Одоо энэ чинь 5 асуудлаас 2 нь хасагдсан. Тэгээд 3 асуудал байгаа. Энэхүү 3 асуудал нь яг орж ирсэн дарааллаараа явбал яасан юм бэ гэсэн ийм горимын саналыг Батчимэг гишүүн гаргасан. Ингээд Батчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Микрофон өгье ажлын алба.

**Д.Мягмарцэрэн:** Сая бол ингээд бусад гэдэг асуудлыг нэгд оруулъя, хоёрт оруулъя гэдэг санал хоёулаа дэмжигдсэн. Санал хураалтын ерөнхий зарчмаар бол

2 ижилхэн санал гараад хоёулаа дэмжигдсэн тохиолдолд дахиж санал хураагаад тэгээд хагалж аль нэгийг нь авдаг. Одоо нөгөө 2-оос дээш удаа олонхын санал авсан санал нь одоо босоо санал гэж үлддэг. Эсвэл асуудлаа хэлэлцэж дуусаагүй хэлэлцүүлгийн аль ч шатад гишүүн саналаа татах эрх нь байдаг тэр зарчмыг бас ашиглаад аль нэг гишүүн нь одоо саналаа татаад болно гэсэн үг.

Хэлэлцүүлэг нь дуусаагүй учраас тэгээд саналаа татах боломж нь байгаа гэсэн үг.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн. Батсүмбэрлэлийн гаргасан хэлэлцэх асуудалтай холбоотой, дараалалтай холбоотой горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

38.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу гишүүний гаргасан хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдолтой горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал нэг.

***БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг***

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Энхжаргалын Сундуй Төв тусгал сургалт судалгааны төвийн судлаач, Жанчивсэнгээгийн Дамбаасүрэн Өмгөөллийн гранд Лекс партнерс компанийн өмгөөлөгч, Доржнамжилын Болд-Эрдэнэ Монголын хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч. Гишүүд дуугаа аядаарай.

Ингээд ажлын хэсгийг танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасныг үндэслэн хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх огноог тодорхой болгох ёстой энэ талаар санал гаргая.

Ердийн журмаар хүчин төгөлдөр болгоно гэвэл 2 дугаар заалтыг төслөөс хасна. Тодорхой хугацаа шаардлагатай гэвэл хэдэн сарын дараа хэдний өдрөөс байж болох вэ?

Цэнгүүн гишүүний микрофоныг.

**С.Цэнгүүн:** Хууль хэрэгжиж эхлэх хугацааг бол 2026 оны 7 сарын 1-ээс эхэлж дагаж мөрдөнө гэдгээр найруулах саналтай байна.

**Р.Сэддорж:** Төсөл санаачлагчаас саналыг сонслоо. Гишүүд санал хураалтад бэлдье.

Саналын томъёолол. БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг энэ хуулийг 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж өөрчлөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

88.9 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн. Хуралдаанд хүн байна уу? Би уншчихъя. Миний бие танилцуулна аа. Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

15.26 цагт

Хэлэлцэх асуудал 2.

Бусад асуудалдаа оръё. 2 дугаар асуудал бусад асуудал байгаа.

### **Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал**

МАН-ын Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Батсүмбэрэл гишүүн танилцуулъя. Намтар унших уу?

**Н.Батсүмбэрэл:** Гишүүддээ мэнд хүргэе ээ.

Дахин мэнд хүргэе. МАН-ын бүлгээс Эдийн засгийн байнгын хорооны даргад Батжаргалын Заяабал Улсын Их Хурлын гишүүнийг нэр дэвшүүлж байна.

Батжаргалын Заяабал нь 1976 онд төрсөн эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. 1994 онд Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, 1999 онд МУИС-ийн эдийн засгийн сургуулийг санхүү эдийн засагч мэргэжлээр, 2017 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2008 онд АНУ-ын Жорж Майсоны их сургуульд Төрийн бодлогын магистрын зэрэг хамгаалсан байна аа.

Ажилласан байдлын тухайд 1999-2000 онд Монгол Улсын Их Хурлын гишүүний туслах, 2002-2005 онд Өрхийн амьжиргаа дэмжих хөтөлбөрийн газарт мэргэжилтэн, 2008-2009 онд Түлш ЭХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газарт хэлтсийн дарга, 2009-2010 онд Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга, 2010-2012 онд ТӨХ-ны Төр, хувийн хэвшлийн түншлэл хэлэлцээрийн газрын дарга, 2012-2013 онд ТӨХ-ны дарга, 2013-аас 2015 онд Монгол Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, 2015-2019 онд Татварын ерөнхий газрын дэд дарга, 2019-2024 онд Татварын ерөнхий газрын даргаар ажиллаж байгаад 2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон байна аа.

Батжаргалын Заяабалын ажлын туршлага, мэдлэг, ур чадварыг харгалзан үзсэний үндсэн дээр Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа болно оо. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны даргад нэр дэвшиж байгаа нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Батжаргал овогтой Заяабалыг нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаарх санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жавхлан сайдыг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

За хэн унших вэ? Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл танилцуулна.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

15.27 цаг

Яг саналын томъёолол хэвлэгдэж байгаа учраас түр хүлээж байя. 200 гаруй санал хураалт байгаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

***“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлэг***

**Р.Сэддорж:** “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх бусад байнгын хороодын санал, дүгнэлттэй танилцъя.

Эхлээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг танилцуулна аа. Гишүүний микрофоныг нээе.

**П.Батчимэг:** Баярлалаа.

Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бүх байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийг баримтлан явуулж тогтоолын төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгасан төслүүдийн талаар тодруулж усны тархалтыг тогтоох зураглалын ажлыг өргөжүүлэх, газрын доорх усны нөөцийг нэмэгдүүлэх ажлыг хаана хийхээр төлөвлөж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай ирэх оны Улсын хөгжлийн төлөвлөгөөг Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдуулах.

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр ард иргэдийн малчин өрхийн амьдралын чанар сайжирч байгаа эсэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд арьс шир зэрэг малын гаралтай бусад түүхий эдийг үнэ цэнтэй болгох тал дээр хэрхэн анхаарч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг ХХАА-н салбарт хэрэгжиж байгаа томоохон төслүүдийн үр дүн, хэрэгжилтийг тооцож үзээд цаашид хэрэгжүүлэхэд анхаарах.

Ялангуяа шинэ хоршоо хөдөлгөөнийг оновчтой хэлбэрээр эрчимжүүлэх, ирэх оны хөгжлийн төлөвлөгөөг дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэх, өмнөх жилүүдийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарал хандуулах, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг ЖДҮ-лэл эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, стандартын шаардлага хангасан ХАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зээлийн хүү, хугацаа, эргэн төлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен малын арьс шир, ноос үнэгүйдэх байдлыг анхаарч малын гаралтай түүхий эдийг боловсруулж байсан өмнөх сайн туршлагыг хэрэгжүүлэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Батчимэг гишүүнд баярлалаа.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Болдын Жавхлан танилцуулна аа. Гишүүний микрофоныг нээе.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад байнгын хороодод шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 56, 66 дугаар зүйлийг баримтлан 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай. Тухайн жилийн төлөвлөгөө өмнөх төлөвлөгөөтэй хэрхэн уялдаатай батлагдаж байгаа талаар, түүнчлэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө ямар байх, Улсын төсвөөс ямар ялгаатай байх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулахаар тусгагдсан нь төрийн албаны чиг үүргийн давхардлыг арилгах хүрээнд хийгдсэн эсэх, төрийн үйлчилгээнд процессын дахин шинэчлэл хийх ажлын үр дүнгийн талаар, Сонгуулийн санал тоолох төхөөрөмж 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд хэвийн ажиллах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл төрийн албан хаагчдын тоог бууруулах цомхотгох бол чиг үүргийн давхардалд анхаарах, тухайн асуудалд орон нутагт хүндрэл үүсгэж байгаа талаар болон төсвийн хэмнэлтийн талаар ямар бодлого баримтлахаар төлөвлөгөөнд тусгагдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон Улсын төсвийг батлахад хариуцлагатай байх халамжийн

бодлогод шинэчлэл хийх, асрамжийн газрууд санхүүжилтээс болж хаагдах байдал үүссэн талаар болон шаардлагатай бол тухайн харилцааг зохицуулж байгаа дүрэм, журмыг өөрчлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Зулпхар мал эмнэлгийн дэвшилтэт технологийн үйлдвэр, мал эмнэлгийн хүрээлэнгийн судалгаа, туршилтын төв байгуулах зорилт малын вакцин үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангаж импортыг орлох зорилтуудыг Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд тусгасан эсэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Болдын Жавхлан

Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх бусад байнгын хороодын санал, дүгнэлттэй танилцлаа.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн дэд ахлагч Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатарыг танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

**Н.Наранбаатар:** Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 194 дүгээр захирамжаар “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц, дэд ахлагч Наранбаатар нараар ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Баасанжаргал, Бадамсүрэн, батбаяр, Ганзориг, Мөнхсайхан, Мөнхтуяа, Нарантуяа-Нара, Очирбат, Пүрэвдаваа, Сэддорж, Ундрам, Уянхишиг нарын гишүүнтэйгээр байгуулсан.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүдээс нийт 206 зарчмын зөрүүтэй санал.

Үүнээс төслийн 1 дүгээр хавсралтад 1, 2 дугаар хавсралтад 64, 3 дугаар хавсралтад 37 санал ирүүлсэн. Ажлын хэсэг 2026 оны 5 дугаар сарын 13, 15, 20-ны өдрүүдэд хуралдаж дээрх зарчмын зөрүүтэй саналуудыг нэг бүрчлэн хэлэлцээд,

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа-2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоол болон холбогдох бусад хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичигт заасан шаардлагад нийцсэн зарчмын зөрүүтэй 64 саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж санал хураах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцээгүй 145 зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзлээ. Холбогдох хуулийн шаардлага хангаагүй зарчмын зөрүүтэй саналуудыг хуульд нийцүүлэх талаар тухайн санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн тус бүрд мэдэгдсэн болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Наранбаатар гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны ТНБД, Лханаажавын Мөнхтүшиг ГХЯ-ны ТНБД, Бат-Ирээдүйн Анар Сангийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нэргүй Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны ТНБД, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД дарга, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны ТНБД, Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны ТНБД, Адьяасүрэнгийн Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Намсрайн Баярмагнай Зам, тээврийн яамны ТНБД, Балдангомбын Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн ХХААХҮЯ-ны ТНБД, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны ТНБД Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны ТНБД, Шаравын Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын Бодлого, зохицуулалтын газрын дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Ерөнхий газрын дарга байна уу? Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энхамгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалт, бодлогын газрын дарга алга байна уу. Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа эдийн засгийн

хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батсуурийн Мөнхбаяр Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал, Мэлсчогийн Мэндбаяр алга байна уу? Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга. Энд нэрээ өгчхөөд ирээгүй хүмүүсийг оруулаарай. Ирэхгүй бол нэрийг нь яах гэж өгсөн юм. Эрхэмбаярын Гансүх Батлан хамгаалах яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, Батчулууны Бат-Өлзий Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны бодлогын газрын дарга, Цэндийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга алга байна уу? Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Юрагийн Отгонбат Отгонбилиг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Баяраагийн Урьболд Спорт, соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Доржийн Энхтөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Батмөнхийн Хишигтогтох. Алга байна уу? Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шалгалт, дотоод аудитын газрын дарга Бямбасүрэнгийн Туяа, ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Батсүхийн Бадамжав Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Зияханы Райымбек, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн бодлого төсөөллийн хэлтсийн дарга, Эрдэнэбатын Батболд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын газрын Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга.

Гадаадад томилолтгүй сайдууд орж ирээрэй. Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Цэндийн Уянга гишүүнээр тасалъя. Болдын Уянга гишүүн.

**Б.Уянга:** Энэ өдрийн мэнд хүргэе. Байгаль орчны яамныхнаас байгаль орчин, барилгынхнаас хүн байгаа байх тийм үү? БХБЯ-наас. Энэ 2027 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө батлах тухай энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр нэг ийм саналыг гаргасан байсан юм аа. Тэр нь юу вэ гэхээрээ одоо энэ Улсын төсвөөр бид нар чинь цэцэрлэг барьж байна, сургууль барьж байна, тэгээд барина, тоог нь нэмнэ гээд байгаа болохоос биш яг ямар барилга барих юм бэ гэдэг дээр ямар нэгэн төлөвлөлт бол байхгүй харагдсан.

Яагаад ингэж хэлж байгаа юм бэ гэхээр бид нар чинь нэг эрчим хүчний хэмнэлттэй барилгуудыг дэмжье, дулаалгаа сайжруулъя гээд аягүй их явдаг. Тэгсэн мөртөө яг манай улсаас баригдаж байгаа барилга дээрээ өөрсдөө энэ

шаардлагуудаа тавьдаг байвал яасан юм бэ гэсэн саналын дагуу санал оруулаад яах вэ ажлын хэсэг дээр бол дэмжигдсэн байгаа юм.

Тэгтэл нөгөө 5 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр энэ одоо агуулга нь орох ёстой учраас гээд саналаа татаарай гээд надаа хэлж байна л даа. Тэгэхээр одоо татах нь байна.

Тэгэхээр энэ дээр яах вэ Барилгын яамныхан хот байгуулалтынхан байвал ер нь аль бодлогын баримт бичигтэй энийг авч хэрэгжүүлэхээр байна. Нэг тийм хариулт авъя. Бас би саналаа хүргүүлъя. Тэгээд яах вэ? Энэ тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2 дээр юу гэж санал өгөөд дэмжүүлсэн байсан гэхээр стандартын шаардлага хангасан орчинтой цэцэрлэг эсвэл ЕБС-ийг бариулъя гэсэн төлөвлөлт бол байна лээ. Энэнийх нь араас тухайн барилга нь эрчим хүчний хэмнэлттэй байя, дулаан алдагдал багатай барилга байя гэсэн ийм төлөвлөгөөнд оруулсан агуулга юм байгаа юм л даа.

Тэгэхээр энийг яах вэ зүгээр болохгүй 5 жилийн өмнөх төлөвлөгөөнд ороогүй учраас татаж авна. Гэхдээ барилгын яамныхан энэ чиглэлээр ер нь ямар төлөвлөлт хийж байна. Яригдаж байна уу. Энэ дээр нэг хариулт хэлээд өгөөч.

**Р.Сэддорж:** Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон хариулъя. Өөрийгөө танилцуулаад.

**М.Баяраа:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД баяраа. Уянга гишүүний асуултад хариулъя аа. Ер нь манай барилгын норм өөрөө ер нь Улсын төсвөөр хийгдэж байгаа барилгууд ... ангиллаар явдаг. Зөвхөн одоо 2023 оны нормд өөрчлөлт оруулаад боловсролын байгууллагын сургууль цэцэрлэгийг Б ангилал буюу эрчим хүчний хэмнэлттэйгээр бариулах чиглэлээр одоо норм батлагдчихсан байгаа. Тэгэхээр энэ маань өөрөө болбол цаашдаа бол бүгдээрээ энэ одоо ногоон буюу эрчим хүчний хэмнэлттэй барилгын ангиллаар баригдана гэсэн үг.

Дараагийн асуудал нөгөө дулаалгатай холбоотойгоор болохоор Германы хамтын ажиллагааны байгууллага, барилга хуучнаар Барилга, хот байгуулалтын яам, тэгээд НЗДТГ-тай хамтарсан дулаалгын төсөл Улаанбаатар хотод эрчим хүчний хэмнэлтийг бий болгох тэрийгээ одоо тоолууржуулах ийм одоо төсөл бол олон Улсын зээл тусламжаар болбол хийгдээд ингээд явж байгаа. Улсын төсөв дээр болоод нийслэлийн төсвөөс тодорхой хэмжээний зардлууд бол энэ дээр гарч байгаа. Уянга гишүүн тодруулж асууя.

**Б.Уянга:** Эрчим хүчний хэмнэлттэй тэр Б ангилал гээд зэрэглэл гээд тэрийг бол ойлголоо. Тэгэхээр яах вэ өөрсдийнхөө төсвөөс санхүүжигдээд барих гэж байгаа сургууль, цэцэрлэг энэ ангилал руугаа эрчим хүчний хэмнэлттэй байдал руугаа явж байгаа юм байна гэж ойлгоё. Дулаан алдагдал багатай бас барилга байх ёстой. Ингэж байж эрчим хүчний хэмнэлт нь илүү сайн явагдана гэж бол энэ барилгынхан нэлээн ярьдгийг та өөрөө ч гэсэн мэдэж байгаа байх.

Тэгэхээр цааш цаашдаа төлөвлөлтдөө энэ дулаан алдагдал багатай гэж бусад бид нар барилгад шаардлага тавьдаг шигээ өөрсдийнхөө барих гэж байгаа барилгууд дээрээ бас шаардлага тавьдаг нь тавих нь зүйтэй байх. Энэ дээр анхаарч ажиллахыг хүсье ээ.

**Р.Сэддорж:** Үг хэллээ. Цэндийн Баатархүү гишүүн.

**Ц.Баатархүү:** Би энийг энэ ажлын хэсгийнхнээс зарчмын асуулт асууя гэж бодож байна. Жил болгоны хөгжлийн төлөвлөгөө бол зөв чиглэл рүүгээ л явж байна гэж хараад байгаа. Энэ жил бол бас энэ экспортыг нэмэгдүүлье экспортод онцгой анхааръя. Тэгээд манай экспортод гарч байгаа бүтээгдэхүүний 80 гаруй хувь нь одоо нам технологийн бүтээгдэхүүн байна гээд оношлоод байна л даа. Тэгээд энэ их хэтэрхий их олон зорилт бас бид нар энэ төлөвлөгөөндөө оруулаад байх шиг байна. 310 зорилт байна. Тэгээд энийг чинь үнэлэхээр үнэлгээ чинь унаад байдаг. Тэгээд дулааны улирал Монгол Улсад ямар билээ. Бүтээн байгуулалт хийх цаг хугацаа чинь ямар билээ. Тэгэхээр зарчмын хувьд энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль дээр би нэг өөрчлөлт оруулах гээд судалгааны ажил эхлүүлчихсэн байгаа.

Нэг жилээр төлөвлөхөө ер нь болиод энэ 5 жилийн төлөвлөгөө тэгээд 1 жилийн төсөв, хагас жилийн хяналт гэдгээр явъя аа. Төсөв гэдэг бол тоогоор илэрхийлж байгаа л төлөвлөгөө. Шууд төсвөө баталж яваад төлөвлөгөө гэж салгаж тавиад төсөв гэж салгаж тавиад энэ нь хоорондоо зөрчилддөг. Хаваржин төлөвлөгөө, гүйцэтгэл, намаржин төсөв гэж явдаг. Их Хурал ч гэсэн нэг их ачаалал авдаг. Та нар ч гэсэн ачаалал авдаг. Энэ зарчмыг ер нь өөрчилбөл яасан юм бэ гэсэн ийм асуулт асуумаар байгаа.

Монгол Улс бол нэг 25-30 жилийн гранд зорилгоо тодорхойлоод 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөгөө тодорхойлоод 3-5 жилийн төсвийн хүрээнийхээ, төсвийн хүрээгээ тодорхой болгоод ингээд жил болгон төсвөө батлаад явбал илүү ойлгомжтой юм биш үү гэсэн ийм санал байгаа. Тэгээд энэ дээр ямар байр суурьтай юм бэ гэдгийг асууя.

**Р.Сэддорж:** Ажлын хэсгийн 5 номер хариулъя. Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Баатархүү гишүүн их чухал асуудал хөндлөө. Монгол Улс 2050 он хүртэл, Монгол Улс нийгэм, эдийн засаг хөгжүүлэх урт хугацааны хөгжлийн бодлогоо тодорхойлж Улсын Их Хурлаар баталсан. Энийгээ хэрэгжүүлэхийн тулд 5, 5 жилээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу төлөвлөгөөгөө гаргаад хэрэгжүүлж байгаа.

Бид 2025 оны 12 сарын сүүлээр 2026-2030 он хүртэл Монгол Улсыг хөгжүүлэх, хөгжлийн бодлого батлагдсан. Тэр бодлогод нийцэж 2027 оны хөгжлийн бодлого орж ирж байгаа. Нэг зүйлийг гишүүд ээ, нэг анхаараад, ойлгоод өгөөч. Одоо ажлын хэсэг дээр гэхэд л 3.2 их наядын 206 санал гарчихсан байна. Бодлогоос гадуур шүү дээ.

Тэгэхээр гишүүд эргээд шүүмжлэлтэй энэ хөгжлийн бодлого яагаад хэрэгжилт сул байгаа тухай хөнддөг. Энэ асуудал эндээ л холбоотой. Төсөв дээр гэхэд л 155 санал 1.4 их наядын төсөвт өртөгтэйгөөр тусдаа гаргадаг. Тэгэхээр яаж бид нар бодлогоо хэрэгжүүлэх вэ. Гэтэл Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль их нарийн болсон. Их Хурлын дэгийн хууль ч нарийвчилсан. Энэ хуулиар тогтоосон дүрэм зөрчиж байгаа бодлогоос зөрсөн бичиг баримтыг батлах нь санал хураалт явуулахыг бүүр хориглосон байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хуулийг бас Эдийн засгийн мэргэжлийн байнгын гишүүдэд бас мэдээлэл өгөх хэрэгтэй шүү. Гишүүдийг хууль зөрчүүлж болохгүй. Үнэхээр ТЭЗҮ боловсрогдоогүй, эх үүсвэр нь тодорхойгүй хөрөнгө оруулалт хэмжээ нь урьдчилан тооцогдоогүй эдийн засгийн үр өгөөж нь батлагдаагүй ийм л төсөл хөтөлбөрүүдийг л оруулж ирж байна. Ингэж ердөө болохгүй. Яагаад энэ хөгжлийн бодлогын өмнө төсвийн хүрээ оруулж ирж байгаа нь эдийн засгийн чинь орлого энэ байна, зардал нь энэ байна. Орон зай чинь энэ байна гээд гаргаад ирж байгаа шүү дээ. Бид нарын орон зай юу байна гэвэл 2027 онд 2 их наядын хөрөнгө оруулалтыг шийднэ. Шинэ хөрөнгө оруулалт шийдэгдэх орон зай байхгүй. Одоо бид нарт 2027 онд санхүүжих ёстой 3.6 их наядын үргэлжилж байгаа төсөл хөтөлбөрүүд байна.

Үүнээсээ шигшээд 2.2 нь оруулъя дээд хязгаар. Бид нар урсгал зардлыг төсвийн хүрээнд Улсын Их Хурал дээр огцом нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор энэ орон зай чинь байхгүй. Тэгээд энд 200 гаруй санал гаргаад зураг төсөлгүй санал оруулаад энэ төсөв дээр суух бололцоогүй, хуулийн зөрчил шууд үүсэж байна. Дэгийн зөрчил шууд үүсэж байгаа ийм л нөхцөл байдалтай байгаа юм. Тэгэхээр ингэж ерөөсөө цаашдаа явж болохгүй ээ. Ингээд одоо Их Хурал өөрөө энэ хуулийг өөрөө зөрчиж эхэлж байгаа байдал үүсчих вий гэж санаа зовж байна. Энэ маань өөрөө тэгээд аймаг орон нутгийн төлөвлөгөөнд шууд тусгагдаад батлагдаад явна.

Энэ хөдөлгөөн улс орны хэмжээний хөдөлгөөн болно. Тэгэхээр улсаараа нөгөө хөгжлийнхөө зорилтоосоо ухарсан, биелүүлээгүй, хүч нөөцөө тарамдуулсан ийм л бодлого болж хүрнэ шүү дээ. Тийм болохоор яагаад төсвийн хүрээ түрүүлж гараад дараа нь бодлого орж ирдэг, тэр бодлогод нийцвэл төсөв зохиогддог учир шалтгаан маань энэ учиртай юм шүү дээ. Тэгэхээр энэ одоо оролцсон энэ төслүүд төсөвт орж ирэх бололцоогүй байхгүй юу даа.

Ялангуяа 2027 онд бид нар энэ урсгал зардлын нэмэгдэлтэй холбоотойгоор шинэ хөрөнгө оруулалтыг хийх орон зай, төсвийн орон зай байхгүй болсон. Үнэхээр бид нар цалинг бол тооцоолсноос хэт их нэмсэн цалин тэтгэвэр. Ийм учраас бид нар НӨАТ-ын хууль буюу төсвийн орлогыг 1.8 их наядаар дутах болчихсон байгаа. НӨАТ-ын хуулийг бол тэр хэрэгжилтийг нь хойшлуулъя гэдэг санал оруулж ирж байгаа учир шалтгаан нь энэ байгаа юм л даа.

**Р.Сэддорж:** Баатархүү гишүүн тодруулж асууя.

**Ц.Баатархүү:** Яах вэ яг Их Хурлын гишүүд бол ингээд ажлын хэсэг гараад санал өгөөд байх тэр хууль зүйн боломжоо бид нар нэг жилийнхээ энэ төлөвлөгөө гэдэгт өгөөд байгаа байхгүй юу. Томоохон бүтээн байгуулалтын ажил нэг жилд хийж амжих эсэх бол Монгол Улсад эргэлзээтэй, зам барилга дандаа он дамжина.

Тэгэхээр энэ 5 жилийнхээ төлөвлөгөөг сайтар тэр дундаа манай Эдийн засгийн байнгын хороо, эдийн засгийн нүдээр нэгмөсөн сайн хийгээд тэгээд шууд төсвөө батлаад явж болох уу гэсэн л би асуулт асуугаад байгаа. Энэ бол хамгийн зөв юм байна аа. Тэгэхгүй бол одоо энэ төлөвлөгөөн дээр манай гишүүд бол иргэдээс ирж байгаа саналуудыг оруулчихдаг. Тэгээд төсөв дээр зарим нь сууна суухгүй тэгээд энэ эдийн засгийн төлөвлөгөөний чинь биелэлт тааруу гарах гээд байна аа. Энийгээ оношилж байгаа нэг оношилгоо чинь хууль зүйн хувьд нэг жилийн төлөвлөгөө гэдэг чинь буруу юм биш үү гэсэн саналыг би Энхбаяр сайд хэлээд байгаа. Тэгэхээр бид нар энэ хуульдаа бас нэмэлт, өөрчлөлт оруулаад явахгүй бол болохгүй юм байна гэсэн саналыг хэлээд байгаа юм Энхбаяр сайд аа.

**Р.Сэддорж:** Хариулъя 5 номер Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Тэр 5 жилийн бодлогоо бид нар бүүр хуульчлаад л баталчихсан. Хэрэгжүүлэх том төслүүдээ бүүр хашаад. Зөвхөн энийг хэрэгжүүлнэ гээд баталчихсан шүү дээ. Улс төрийн намууд хүртэл сонгуульдаа зөвхөн энэ хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг дээрээ л уралдана. Хэрвээ энэнээс зөрчих юм бол сонгуулиас жагсаалтаас шууд хасах заалттай. Бүр тийм зохицуулалттай, улс төрөөс ангид, бодлого тогтвортой хэрэгжихүйц байх буюу бодлогыг одоо яг тогтвортой хэрэгжүүлэх үүднээс ингэж хуульчилж 5 жилээр бүр хашиж өгсөн. Тэгэхээр жил жилийн төлөвлөгөөндөө Эдийн засгийн байнгын хороо аль төслүүд нь тэргүүлэх энэ цаг үед хэрэгтэй байна гэдэг дээрээ л ярьж тэрийгээ урд хойно нь оруулах асуудал байх ёстой байхгүй юу.

Тэрнээс шинэ төсөл оруулна гэхээрээ маш олон хуулийн заалт нөгөө тусгай шаардлагуудаа зөрчөөд, тэрийгээ ярилцаад, тэгээд санал хураагаад ингээд нөгөө улс орны хөгжлийн бодлогоо энд эвдээд байгаа юм. Тэгэхээр тэрийг хийж байгаа одоо яг энэ ажлын хэсгийн гишүүдэд ингээд харахад бол Эдийн засгийн байнгын хорооны гишүүд бараг нэг байна уу 2 хүн бусад нь ингээд өөр.

**Р.Сэддорж:** Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Баатархүү гишүүн нэг минут.

**Ц.Баатархүү:** Яах вэ бид нар яах вэ хууль дээрээ нэг нэмэлт, өөрчлөлт оруулъя гэсэн юмыг Их Хурлын гишүүд яриад байгаа юм л даа. Энэ маань юу юм бэ гэхээр танай эдийн засгийн энэ төлөвлөлт хийж байгаа газар ч гэсэн их амар болно. Би бас сайн ойлгуулж чадахгүй байх шиг байна.

Хоёр дахь зүйл жишээ нь одоо энэ 5 жилийн төлөвлөгөө гэж үнэхээр байгаа бол мөрддөг бол 3 Засгийн газар солигдоход 3 өөр төлөвлөгөө өөр нь орж ирж байгаа шүү. Хамгийн эхний Засгийн газар бол энэ мега төслүүдээ явуулъя гэж байтал дараагийн Засгийн газар арай өөр төлөвлөлт оруулж ирсэн. Энэ удаагийн Засгийн газар өөр төлөвлөгөө оруулж ирж байна. Та яг энэ эдийн засгийн бодлого хариуцаж байгаа Шадар сайдын хувьд ч гэсэн энийг харах хэрэгтэй. Засгийн газар Тэр дундаа нэг намын чинь Засгийн газар солигдохоороо ингээд бодлогоо биш бодлоо оруулж ирээд байна. Тэгээд Монгол Улс бол шинжлэх ухаанд суурилсан хөгжил дэвшлийг бий болгох хэрэгтэй. Тэгээд институцийн онол байдаг юм уу системийн динамикийн онол байдаг юм уу. Энэ 15, 20 жилийнхээ төлөвлөгөөг нэг симуляц хийж харах хэрэгтэй шүү дээ.

**Р.Сэддорж:** Үг хэллээ. Батбаярын Жаргалан гишүүн алга байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Гишүүд танхимд орж ирье. Санал хураалт явагдах гэж байна. Гишүүд танхимд орж ирье.

Гишүүд санал хураалтад бэлэн болсон байна.

Гишүүд байраа эзэлье. Санал хураалтаас өмнө хууль сануулъя.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т 1 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна.

6.10.2.санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон хариуцах эзэнтэй ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл арга хэмжээг эрэмбэлсэн байна.

9.2.9.Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7-д заасан хөгжлийн бодлого төлөвлөлт тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуульд заасан зарчмыг баримтлаагүй, шаардлагыг хангаагүй хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэн батлахгүй байх,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйл.

Хуралдаан даргалагчийн эрх үүрэг

13.2.Хуралдаан даргалагч горимын саналаар нэг удаа санал хураалт явуулна. Хуралдааны хэлэлцэх асуудалд ороогүй асуудлаар мөн тухайн санал нь хуулиар тогтоосон журмыг зөрчиж байгаа бол санал хураалт явуулахыг хориглоно оо гэсэн хуулийн заалттай юм байна.

Ийм учраас зарчмын зөрүүтэй саналууд хуульд нийцээгүй бол одоо санал хураалгахгүй байж болох ийм зохицуулалттай юм байна.

Ингээд санал хураалт.

Тухайн тухайн санал дээрээ одоо холбогдох яамдуудаас асуугаад ингээд явъя аа.

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх;

“3/Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд үзүүлэх нөлөөллийг хэмжих аргачлал, үнэлгээний үзүүлэлтийг боловсруулж, 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Заяабал гишүүнийг дэмжсэнээр протоколд авъя.

Гишүүд байраа эзлээрэй.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалт Доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

4/“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-ийг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөө болон улсын төсвийн төслийг боловсруулахдаа бүрэн тусгасан байх; Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

### **Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал:**

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

“Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотод Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулж бүс нутгийн түвшинд хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт манлайлан, хүний эрхийн салбарын хамтын нийгэмлэг, үндэсний хүний эрхийн байгууллагууд (NHRI), иргэний нийгэм, эрдэм шинжилгээ, судалгааны зангилаа төв болон хөгжиж, аялал жуулчлал шинэ урсгалыг бий болгож, эерэг үр дүн гарна.” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжсэн санал ажлын хэсэг дээр.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал нэг тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтын хөтөлбөрийн үр дүн Стандартын шаардлага хангасан орчинтой, эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдал багатай барилга бүхий цэцэрлэгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан ажлын хэсэг.

Уянга гишүүн.

**Б.Уянга:** Түрүүн барилга БХБЯ-аас асуугаад байсан санал юм байгаа юм аа. Стандартын шаардлага хангасан орчинтой, эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдал багатай барилгыг төсвөөс баригдаж байгаа барилгуудад шаардлага болгон тавья гэсэн санал байсан юм. Тэгэхдээ энэ маань 5 жилийн төлөвлөгөөнд тусгаагүй байгаа учраас яг ингэж оруулж болохгүй гэсэн байгаа. Тэгэхээр энэ 2 дугаар хавсралтын нэг болон 2 дугаар санал хоёулаа адилхан. Тэгэхээр хоёуланг нь татъя.

**Р.Сэддорж:** Ажлын хэсгийн ахлагч Наранбаатар гишүүн татах уу энэ 2-ыг.

Микрофонд хэлчих, татъя гээд Наранбаатар гишүүн.

**Н.Наранбаатар:** Дэмжиж байгаа бас татах саналыг.

Ингээд тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1 2 дугаар саналыг татлаа.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.2.2.2 дахь дэд заалтын Төсөл арга хэмжээ “Хиймэл оюун ухааны программ хангамжийн нэмэлт сайжруулалт хийх”, гэснийг “Хиймэл оюун ухааны тоног төхөөрөмжийн нэмэлт сайжруулалт” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.1.3, МУШЭМХББ-3, МУХТЖҮЧ-5.1” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “0” гэснийг, “3,700.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “0” гэснийг 1,500.0” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Батболд гишүүн горимын санал гаргаж байна.

**Р.Батболд:** Сая нөгөө төхөөрөмж хоцроод ажиллачихлаа. Энэ уншсангүй. Уул нь зөв яасан юм дэмжсэн юм. Энэ саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахиад хураалгачих уу?

**Р.Сэддорж:** Батболд гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгосон саяын сүүлийн санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ

4.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “10.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.4.1, 2.4.2, 2.4.3, 2.4.4, МУХТЖҮЧ-10.1.1.1, ЗГҮАХ-3.3.7.1, 3.3.7.3, 3.3.7.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Малын эрүүл мэндийн дэвшилтэт технологийн үйлдвэр байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “10,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Төр, хувийн түншлэлийн гэрээ” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Ижилхэн 2 санал байгаа юм байна.

Хамтад нь хураах юм байна.

5.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 10.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.4.1, 2.4.2, 2.4.3, 2.4.4, 2.4.6, МУХТЖҮЧ-10.1.1.1, ЗГҮАХ-3.3.7.1, 3.3.7.3, 3.3.7.5” гэж, Төсөл арга хэмжээ “Малын эрүүл мэндийн дэвшилтэт технологийн үйлдвэр байгуулах (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “7,027.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “3,514.0” гэж,

Санхүүжилтийн эх үүсвэр “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ” гэж, Үндсэн хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх.

Ингээд ижилхэн санал учраас нийлүүлээд нэг санал хураалт явуулна. 4 дэх санал хураалт.

Одоо гишүүд 4 дэх санал 50 хувьтай дэмжигдээгүй учраас 5 дахь санал яг ижилхэн одоо төрлийн 2 үйлдвэр байна. Үйлдвэрийн төсөл байна. Ингээд 5 дахь саналаар санал хураана. Та бүхэн уншиж байгаа биз. 5 дахь санал. Хан-Уул дүүрэг одоо Био комбинат гэсэн үг тийм үү. Одоо малын эрүүл мэндийн энэ мал эмнэлгийн шинжлэх ухааны одоо гол ажлаа л ингээд зориод яваад байгаа юм байна гэж бид ойлгож байгаа. Ингээд Био комбинат.

Санал хураалт. Ажлын хэсгийн санал. 55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтын “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Хүрэн нүүрснээс хагас кокс эрчим хүч үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Тайлбар авах уу? 5 номер.

**Ж.Энхбаяр:** Гишүүд ээ яг эхний санал дээрээс л бид нар нөгөө Үндсэн хуулийн бодлого тогтвортой байна гэдгийг л зөрчиж эхэлж байгаа байхгүй юу. Хиймэл оюун ухааны программ хангамжийг нэмэлт сайжруулах гэснийг л програм хангамж гэдгийг нь өөрчлөөд л тоног төхөөрөмжийг нэмэлт сайжруулалт болгоод л тоног төхөөрөмж дээр 3.7 тэрбум төгрөг тавиад л эхэлж байгаа юм. Ингээд зөрчил рүү л ороод байна. Би зүгээр болохгүй гэдгийг нь л одоо сануулаад байна шүү. Хууль сануулна гэдэг чинь учир нь дандаа дараа нь эрх зүйн асуудал үүсдэг. Энэ чинь бодлогыг батлагдсан бодлого хуульчлагдаад 5 жилээр батлагдсан бодлого байхгүй юу. Хиймэл оюун ухааны программ хангамжийн нэмэлт сайжруулалт гэж. Энийг нь өөрчлөнгүүтээ тоног төхөөрөмжийн нэмэлт сайжруулалт гэж өөрчилж байгаад нэг тавьж байгаа юм.

**Р.Сэддорж:** 6-г санал хураах юм уу? 6 дээр тайлбар. Яагаад тасалсан юм бэ?

**Ж.Энхбаяр:**Засаг бол оруулсан бодлогоо л хамгаална шүү дээ байж байгаа.

**Р.Сэддорж:** Тэгвэл юу юм байна Наранбаатар ажлын хэсгийн гишүүн. Ажлын хэсэг санал хураах юм уу, хураахгүй юм уу гэдэг дээр тайлбар 2 номер.

**Б.Дашпүрэв:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД Дашпүрэв. Энэ Багануурыг нүүрсний уурхай дээр түшиглэн нүүрсийг пиролизын аргаар боловсруулах үйлдвэрийн төсөл зураг төсөл бүх юм нь батлагдаад одоо туршилтын үйлдвэрлэлийн үр дүн нь хийгдчихсэн. 5 сарын 30-нд тайлан нь гарна. Сайн үр дүн гарч байгаа. Тийм учраас бид бүхэн бол 2027 онд энэ явцаараа бол ашиглалтад оруулах бүрэн боломжтой төсөл өө гэж ингэж үзэж байгаа. Тийм учраас хасахгүй оруулж өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Санал хураахгүйгээр шийдлээ. Одоо хууль зөрчиж байна шүү дээ хэвээрээ үлдэж байна гэсэн үг.

7.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-6.4.7, 6.4.9, 6.4.11, 6.4.16, МУХТЖҮЧ-6.2.1.1, ЗГҮАХ-3.4.2.1, 3.4.2.2”, Төсөл арга хэмжээ “Айл өрхийн сууцны дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй халаалт, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжид зориулсан ногоон зээлийн хүүгийн татаас олгох” гэж, Шалгуур үзүүлэлт “Дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй шийдэл нэвтрүүлсэн айл өрхийн тоо” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “5,000” гэж, Зорилтот түвшин “38,000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “300,000.0” гэж, Тухайн жилд шаардагдаж санхүүжилтэд сая.төг “100,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

**Р.Сэддорж:** Энхбаяр сайд 5 номер.

**Ж.Энхбаяр:** Урсгал зардлаа яаж шингээх вэ гээд шинэ хөрөнгө оруулалтгүй байж байхад ингээд 300 тэрбумын эх үүсвэрийг ингээд л тавьж байна гэдэг чинь яагаа ч юм. Ийм хариуцлагагүй байж болохгүй шүү дээ. Энэ чинь эдийн засгийн хөгжлийн бодлоготой төлөвлөлтийн бичиг баримттай тэнд нийцүүлээд орж ирж байгаа асуудал шүү дээ. Ингээд хөндлөнгийн ийм зүйлүүд ерөөсөө яагаад ч болмооргүй л байх юм. Байнгын хороон дарга аа. Үндсэн хуульд бол тэр бүр нэмэлт оруулж байж хөгжлийн бодлого тогтвортой байна, улс төрөөс ангид байна, хөдөлгөж өөрчилж болохгүй гээд ингээд хуульчлаад явж байгаа ажил шүү дээ. Тэгээд одоо ажлын хэсэг гэдэг маань хэн бэ гээд. Одоо энэ дотор ажлын хэсэгт орсон хүн байна уу? Одоо гишүүдээс. Тийм ганц Наранбаатар Очирбат 2 л байх шиг байна.

Ингэж болмооргүй байна. Энэ бол энэ Их Хурлын нэр хүнд. Ер нь энэ олон ийм суурь зарчмыг хөндөж эхэлж байна шүү дээ. Одоо тэрийгээ та нар жоохон болгоомжтой байгаач дээ гэж.

Энэ чинь Улсын төсөв гэж байхгүй юу. Санхүүжилтийн эх үүсвэр Улсын төсөв 300 тэрбум эх үүсвэр гэж тухайн жилдээ 100 тэрбум гаран.

**Р.Сэддорж:** Төсөвт ачаалал өгөхөөр бол хураахгүй явчихвал яадаг юм. Энэ саналыг. 5 номер Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** 206 саналаас хуулийн зөрчилтэй тэр 140, 50 саналаа шууд бөөнөөр нь нэгэнт хуулийн зөрчилтэй бол шаардлага хангаагүй гэж хасаад шаардлага хангасан гэж үзэж байгаа 50, 60 санал байсан шүү дээ. Тэрэн дээрээ их нарийн нягт яриад бодлоготойгоо уялдаж байна уу гээд явбал цаг хэмнэнэ. Ийм маягаараа бол бид нар 6, 7 цагийн ажил болно шүү дээ.

**Р.Сэддорж:** Энэ чинь харин нарийн явж байна шүү дээ. Харин тийм яг нарийн эхнээсээ явж байна.

**Ж.Энхбаяр:** Нэгэнт ажлын хэсэг бол хуулийн шаардлага нийцээгүй гээд саналаа өгчихлөө шүү дээ. Тийм болохоор энийг заавал санал хураах шаардлагагүй. Яагаад гэвэл Дэгийн хууль болон.

**Р.Сэддорж:** Та энэ 7 дугаар саналыг хураах шаардлагагүй гэж үзэж байна уу?

**Ж.Энхбаяр:** Шаардлагагүй. Энэ чинь 300 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг одоо Улсын төсөв дээр тавь гээд орж ирж байна шүү дээ 300 тэрбум. Гэтэл Улсын төсөв дээр чинь хөрөнгө оруулах орон зай чинь юу байгаа билээ гэдгээ бид нар мэдэж байгаа шүү дээ.

2.2 их наядын чинь хөрөнгө оруулалт биш шилжих хөрөнгө оруулалтын л орон зайтай байгаа дээр ийм юм тавьчаад тэгээд хэрэгжсэнгүй гээд эргээд намрын одоо төсвийн үеэр энэ чинь бөөн маргаан хэлэлцүүлэг өрнөөд нөгөө бодлого хэрэгжихгүй нөгөө үнэлгээ чинь буруу гараад эхэлнэ гэсэн үг шүү дээ.

Ажлын хэсгээс Очирбат гишүүн хариулъя.

**Г.Очирбат:** Энэ ер нь бол ажлын хэсэг анх хуралдахдаа энэ Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиуд ингээд хоорондоо их зөрчилтэй байна аа. Сүүлийн 10 жил бол ингэж явж ирсэн байна. Тэгээд ажлын хэсгээс бол энэ хуулийн төслийг өөрчилъе гэсэн санал санаачилга гарсан байгаа, 1 дүгээрт.

Хоёрдугаарт гэх юм бол энэ ажлын хэсэг ажиллахад Эдийн засаг, хөгжлийн яамныхан, Энхбаяр сайд аа, танай яамны хажууд чинь сууж байгаа бүх хүмүүс Сангийн яам сайд нь байна уу. Сангийн яамны бүх мэргэжилтэн, гишүүд, Эдийн засгийн байнгын хорооны референтүүд бүгд сууж байгаад ажилласан. Бид хуулийн дагуу ажилласан, ирцээ бүрдүүлэх гэж хүртэл бүтэн шөнөжингөө сууж ажилласан. Тэгээд энэ Их Хурлын гишүүний бас бүрэн эрх ажлын хэсгийн дарга Лувсанжамц гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд зарчмын зөрүүтэй санал гар гаргаж оруулж ирээд явж байгаа юм.

Тэгээд та энэ зарчмын зөрүүтэй саналыг нь үзэх юм бол Алсын хараа Монгол Улсын алсын хараа-2050-ын 6.4, 6.7, 6.9, 6.4.11, 6.4.16 Монгол Улсын хөгжлийн 5 жилийн хөтөлбөр гээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гээд ингээд бүгдэд нь суугаад шингэчихсэн. Хууль зөрчсөн зүйл байхгүй гэдгийг танай яамныхан болон Сангийн яамныхан оруулж ирээд дэмжихээр оруулж ирсэн байгаа. Тэгээд бид ажлын хэсэг дээр дэмжихээр бол энэ хууль зөрчөөгүй бол дэмжээд явъя гэдэг шийдвэр гаргасан. Тэгэхээр та харин наад хажуудаа сууж байгаа хүмүүсээсээ нэг бол асуу л даа, яамныхнаасаа. Бид хууль зөрчөөд байгаа юм уу та одоо ямар сонин юм бэ? Яг зэрэгцээд сууж байгаа бүх хүмүүс чинь өчнөөн хоног ажиллаад оруулж ирж байна.

Тайлбараа наад хажууд сууж байгаа хүмүүсээсээ ав. Одоо ажлын хэсэг энэчээ зарчмын зөрүүтэй саналууд дээр хуульд нийцсэн нийцээгүйг нь ялгаж оруулж ирсэн. Эдийн засгийн байнгын хороо саналууд дээрээ санал хураагаад асуудлаа шийдээд урагшаа ажил явах ёстой ийм зарчмын байр суурьтай байна.

**Р.Сэддорж:** 3 номер тайлбарлая.

**Б.Дашпүрэв:** Одоо багш энэ нөгөө 300 тэрбум дээр болохоороо юу яасан л даа. Ажлын хэсэг дээр нөгөө ярьж байхад нөгөө 2 удаа ороод ирчихсэн байсан санал нь. Тэгээд 1 нь улсын төсвөөр гээд. Тэгээд нэг нь төр хувийн хэвшлийн

түншлэлээр гээд явж байсан. Тэгээд тэрэн дээрээ бид нар нөгөө ярилцаад төр хувийн хэвшлийн түншлэлээр гэдэг дээрээ санал хураасан санагдаж байна.

**Ж.Энхбаяр:** Ажлын хэсгийн дарга Наранбаатар гишүүн. Лувсанжамц гишүүн уг нь дарга нь тийм ээ. Дэд дарга ажлын хэсгийн дэд дарга.

**Н.Наранбаатар:** Энэ саналын тухайд бол Лувсанжамц гишүүний гаргасан санал байгаа юм. Тэгээд ажлын хэсэгт болон Байнгын хороонд гишүүд чинь зарчмын зөрүүтэй санал гаргах эрх нь нээлттэй байхгүй юу. Ингээд тэр гишүүдийнхээ одоо бүрэн эрхийнхээ дагуу ингээд саналаа ажлын хэсэгт ирүүлсэн. Бид нар хураах үүрэгтэй. Энийг харвал хууль зөрчсөн юм юу ч байхгүй байгаа байхгүй юу. Бид нар хураахаас өөр арга байхгүй. Тэгээд хураагаад олонхоороо шийдсэн нь зүгээр. Энэ дээр асуудал нь төсөв л байгаа юм. Тийм тэгэхээр зэрэг гишүүний гаргасан нэгэнт зарчмын зөрүүтэй саналыг санал хураагаад л шийдэх нь зөв. Дэмжих дэмжихгүй нь хамаагүй.

**Р.Сэддорж:** 5 номер.

**Ж.Энхбаяр:** Ингээд нэг нь 300 тэрбум, нэг нь 600 тэрбум гол нь энэ маань байна шүү дээ. Санхүүжилтийн эх үүсвэр нь бүүр тодорхойлчихсон. Хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилаад бүүр тооцчихсон, дүгнэлт гарчихсан, хариуцах эзэн нь гарчихсан. ТЭЗҮ зураг төсөв нь батлагдчихсан. Тэгээд тэр нь байхгүй яваад байгаа байхгүй юу. Тэгээд энийгээ гишүүний бүрэн эрх гэж ярьж ерөөсөө болохгүй. Энэ чинь Үндсэн хуульд бол тэр нэмэлт, өөрчлөлт оруулаад бодлогыг өөрчилж болохгүй гэж оруулчихаад байхад хууль давсан Их Хурлын бүрэн эрх гишүүний эрх гэж байхгүй шүү дээ.

Тийм болохоор гишүүд энэ асуудлыг хэлэлцэхдээ яг энэ шаардлага тавих ёстой байхгүй юу. Хуульд нийцүүлээд шаардлага байна уу? Энэ ТЭЗҮ-тэй, ийм учиртай, эзэнтэй, төсөвтэй, эх үүсвэртэй болсон байна гээд оруулах ёстой болохоос биш гишүүн өөрөө амаар үнэ зохиогоод янз янзын ломбид орж гаргасан саналыг хураах нь хууль зөрчсөн өө гээд энэ хуулийг чинь нэлээн чангатгаад бодлогоо одоо ингээд тогтвортой болгоё, улс төрөөс ангид байлгаж гээд баталчихсан байхгүй юу.

Бүүр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаад хийсэн ажил байхгүй юу даа. Тэгээд тэр зарчим чинь одоо байнгын ажлын хэсэг дээр яригдаж чадсан юм уу. Тэр болгоны ТЭЗҮ-ийг та нар үзэж хянаж чадсан юм уу? Тэрийг хийсэн мэргэжлийн улсууд эх үүсвэрийг нь тооцсон юм уу л гэдэг чинь байхгүй байхгүй юу даа. Тэгээд 3.6 их наядыг оруулж ирчхээд одоо батална гээд тэгээд хөгжлийн бодлогоо эвдээд энэ чинь төсөв дагаж эвдэрнэ, орон нутгийн бүх бодлогууд эвдэрнэ. Ингээд хэрэгжих бололцоогүй болно.

Нийгэмд буруу ойлголт, буруу хүлээлт үүснэ. Бүгдээрээ энийгээ л больё гэж энэ чинь том Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуультай, 5 жилийн төлөвлөгөөтэй, төсвийн хүрээнд урьдчилж ордог ийм санхүү төсвийн сахилга батыг мөрдүүлье гэж өнгөрсөн 35 жилийн парламентын түүх гашуун туршлага дээр тулгуурлаж энэ хийсэн улс төрийн 5 нам зөвшилцөж, Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт байхгүй юу даа.

**Р.Сэддорж:** Гишүүд байрлалаа эзэлье.

Санал хураалт явагдана. 7 дахь санал хураалт дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.8 “Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ.” гэснийг “1.2.1.8. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг тогтмолжуулна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-2.2.3, МУХТЖҮЧ-1.2.1.8, ЗГҮАХ-2.3.1.1” гэснийг “АХ-2.2.3, 2.2.5, МУХТЖҮЧ-1.2.1.1, 1.2.1.8, ЗГҮАХ-2.2.1, 2.3.1.1” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.1 дэх дэд заалт 1.2.1.1.1” Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах эмнэлэг, эрүүл мэндийн барилгуудыг үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах” гэснийг “1.2.1.1.1.Аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв, байгуулах” гэж, Зорилтот түвшин “100” гэснийг “20” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

10.Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЕЗ/ хөтөлбөрийн нэр “71804 Мэргэжлийн боловсрол”, Үр дүн “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” гэж, Шалгуур үзүүлэлт “Багшийн үндсэн цалин (Улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно)” гэж, Тогтвортой хөгжлийн зорилго “4.с.1” гэж, Хэмжих нэгж “Индекс” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “2,726.9” гэж, Зорилтот түвшин-2027 “2026 оны түвшнээс дээгүүр” гэж, Мэдээллийн эх сурвалж “Үндэсний статистикийн хороо, боловсролын яам” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “Жил тутам” гэж, Хариуцах байгууллага “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Мөнхтуяа гишүүний санал байна.

Санал хураалт.

50 хувиар санал дэмжигдсэнгүй.

11.Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЕЗ/ хөтөлбөрийн нэр “71801 Сургуулийн өмнөх боловсрол”, Үр дүн “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” үр дүнгийн хүрээнд Шалгуур үзүүлэлт “Багшийн үндсэн цалин (Улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно)” гэж, Тогтвортой хөгжлийн зорилго “4.с.1” гэж, Хэмжих нэгж “Индекс” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “2,726.9” гэж, Зорилтот түвшин-2027 “2026 оны түвшнээс дээгүүр” гэж, Мэдээллийн эх сурвалж “Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүй “Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан” гэж, Мэдээлэл цуглуулах давтамж “Жил тутам” гэж, Хариуцах байгууллага “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ дээр Боловсролын яамнаас гишүүдэд хариулах хүн байна уу? Боловсролын яам нэг номер.

**Т.Ням-Очир:** Боловсролын яамны ТНБД Ням-Очир. Энэ Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний 3 дугаар хавсралт дээр нөгөө суурь түвшнээ суурь ерөнхий боловсрол дээр 1 сая 484, СӨБ дээр 1 сая 559 гээд авчихсан байгаа. Энэ 10, 11, 12 дугаар юутай холбоотой? Тэгээд ҮСХ-оос гаргасан үзүүлэлтийн дагуу суурь түвшингээ 2 сая 700 одоо саяын уншсан суурь түвшнээ гэж өөрчилж авч байгаа. Ийм л зүйл байгаад байгаа. Төсвийн үр дагавар юм байхгүй. Харин сая нөгөө 50, 50-аар унасан заалт СӨБ ерөнхий боловсрол дээрээ бид нар одоо нөгөө Улсын дундаж цалингаас доогуур гэж авчхаад мэргэжлийн боловсролоо орхичихсон байсан. Тэгээд мэргэжлийн боловсролоо нэмж уг нь томъёолж оруулсан тийм л зүйл байгаа юм. Тэрнээс биш төсвийн үр дагавар байхгүй.

Тийм суурь түвшнээс сая 484 гэснийг л бид нар ҮСХ-оос гаргасан дүнгээр авч байгаа нэмж авч байгаа гэсэн үг.

**Р.Сэддорж:** Санал хураалт.

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 3 дугаар хавсралтын Салбар/ТЕЗ/ хөтөлбөрийн нэр “71802 Ерөнхий боловсрол”, Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” гэсэн үр дүнгийн Суурь түвшин 1484 гэснийг 2769.9 гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.3 дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.27”, “МУХТЖҮЧ 2.2.12”, “ЗГҮАХ 2.3.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Бүсийн оношилгоо эмчилгээний төвд MRI оношилгооны тоног төхөөрөмж (Дорнод, Хэрлэн) гэж, Шалгуур үзүүлэлт “Стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмж” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “1” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,120.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,120.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

5 номер.

**Ж.Энхбаяр:** Энэ АХБ-ны санхүүжилт, зээлийн санхүүжилтээр 17 аймгийн төвийн эмнэлгүүдийг 2 дугаар шатны эмнэлэг болгох тусламжийн чадвар үйлчилгээ сайжруулах гээд энэ чинь том багц явж байгаа. Боловсролын салбар дээр бол хангалттай цалин нийгмийн асуудал шийдэгдчихсэн. Тэгэхээр эрүүл мэнд, боловсрол дээр ерөөсөө мөнгө тавих орон зай шаардлагагүй байхгүй юу даа. Тулгаад байгаа юм чинь эрчим хүч чинь хүндэрчхээд байна шүү дээ. Эрчим хүчдээ их анхаарах тэр орон зайг бид нарт хэрэгтэй байна шүү дээ. Одоо нийгмийн чанартай эрүүл мэнд, боловсролын төсөл бол гадаад зээл, нийгмийн асуудал, цалин тэр суурь итгэлцүүр хангалттай. 2027 онд гэхэд 4 их наядын ачаалал үүсэж байна шүү дээ. Энэ 2 цалингийн нэмэгдэл орохтой холбоотой.

Тэгэхээр энийг энэ салбарын асуудлуудыг хойш нь тавимаар байгаа юм. Хангалттай эх үүсвэр бол гадаад зээл юмнууд шийдэгдсэн

**Р.Сэддорж:** 13 дугаар санал дээр санал хураалт.

38.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

14.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.2, 3.2.1, 8.3.6, 4.4.1.3”, “ЗГҮАХ 3.4.11” гэж, Төсөл, арга хэмжээ “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах /Дорнод аймгийн Хөлөнбуйр сум/ гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,850.1” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “925.1” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

5 номер.

**Ж.Энхбаяр:** Энэ төрийн албан хаагчдын орон сууц нийгмийн асуудлыг сайжруулах гээд энэ том багц бодлогын арга хэмжээ явж байгаа шүү дээ. Ингээд жиргээд улс орны хөгжлийн бодлого дээр сумын түвшинд шийднэ гээд задлаад эхэлбэл, энэ 330 сум, энэ 126 гишүүн, тойргийн асуудал гээд энэ чинь маш тогтворгүй бөгөөд байж боломгүй асуудал руу орох гээд байна шүү дээ. Нэг сум явбал бусад бүх сумууд л явуулна. Бүгд сумдаа хайртай сумынхаа төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг бодно гээд л явчихна шүү дээ. Энэ чинь бодлогоороо ингээд явж байгаа энэ зорилтын хүрээнд тэгээд ээлж дараатай юм явдгаараа л явж байгаа шүү дээ. Ингэж жиргэж задалж ерөөсөө болохгүй. Энийг тэгэхээр дэмжиж болмооргүй л байх юм.

**Р.Сэрддорж:** Энэ чинь одоо орж ирсэн төсөл дээр байгаа^ Үийт одоо Улсын хэмжээнд төлөвлөсөн төлөвлөлтөд нь байгаа. Наад ном дээр чинь байгаа анх орж ирсэн төсөл байгаа юм аа.

Ундраа гишүүн асуулт асууя.

**А.Ундраа:** Энэ төрийн албан хаагчид орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад энэ төрийн албан хаагчдын орон сууцын асуудлыг шийдэх нь болбол бас бодлогын хувьд их чухал байгаад байгаа гэж харж байгаа. Тэгэхээр яах вэ нийтээр нь шийдье гэдэг тэр зарчмыг болбол бас дэмжиж байна. Төрийн албан хаагчдын ялангуяа орон нутагт дутагдалтай байгаа албан хаагчид тухайлбал одоо нарийн мэргэжлийн байгалийн шинжлэх ухааны багш, нарийн мэргэжлийн эмч, малын эмч дутагдалтай байна зэрэг асуудлууд бол гарч ирдэг ярьдаг. Тэгэхээр сая өнгөрсөн жилүүдэд бас Хот байгуулалтын яам хариуцаад 10 сум дээр санагдаж байна 8 сум дээр билүү энэ төрийн албан хаагчдын барилгыг орон сууцыг бол барьсан тийм ээ.

Тэгэхээр энэ дээр бол төсвийн төсвийг нь төлөвлөхдөө зарим газар бол жишээлэхэд 1 тэрбум орчим төгрөгөөр 8 айлын орон сууцыг ногоон барилгаар барьж болж байсан. Гэтэл зарим сумдууд дээр ер нь төсөв нь бол маш их хэтрэлттэй байгаа. 2 тэрбум, 2.5 тэрбум болж таараад тэгээд яагаад яг ижилхэн 1,

1 тэрбумаар зарим нь ногооныг бариад байж чаддаг. Тэр нь урсгал зардал багатай, ашиглалтын зардал багатай.

Амьдарч байгаа хүндээ агаарын чанар сайтай дотроо ариун цэврийн асуудлаа шийдсэн ийм байдлаар хийгээд байж болдог. Яагаад зарим нь тийм өндөр үнээр хийгдээд байдаг юм бол оо. Тэгэхээр энэ дээр нэгмөсөн шийдье гэж байвал 1 дүгээрт санхүүгийн хувьд хэмнэлттэйгээр, 2-т гэвэл бас урсгал зардал бага байхаар ингэж шийдэх нь бол зөв зүйтэй гэж харж байгаа.

Энэ дээр бас хариуцсан яам, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамнаас тодруулж асуух гэсэн юм Сэдээ дарга аа. Тэгэхээр тэр нөхцөл байдал ямар байгаа талаар тэгээд энэ дээр яагаад 1.8 тэрбум гэж орж ирсэн юм. 1 тэрбумаар тэгээд хэмнэлттэйгээр шийдэж болоод байсан санагдаад байна л даа. Тэгэхээр энэ төрийн нарийнаас нь тодруулж асуух гэсэн юм.

**Р.Сэддорж:** Барилга, хот байгуулалтын яам. Энэ чинь одоо их чухал орон сууц байна шүү дээ. Төрийн албан хаагчийн. Тийм багш, эмч нар, малын эмч, багш нар тиймээ? Тэр бүс нутагт чинь тэгээд хэн очиж ажиллах юм. Орон сууц энэ чинь хамгийн чухал шүү дээ. Хэдэн номер вэ? 2.

**М.Баяраа:** Сая Ундраа гишүүний хэлдэг бас их зүйтэй зөв зүйтэй энэ төсөвтөө багтааж. Ер нь бол анхны концепц бол сумдад бол тэрбум төгрөгийн төсөв тавиад тэрэндээ сонгон шалгаруулалтаа хийгээд ерөнхийдөө дунджаар 1 800-аас 900 сая төгрөгт бол сумын одоо 8 айлын орон сууцыг бол барьж байгаа. Сая 12 одоо айлын орон сууц бол ингээд баригдаад дуусаж байна. 6 байрлал дээр болбол Улсын комисс ажиллаад ингээд хүлээж авсан байгаа. Ер нь бид нар сая явж үзсэн бас газар дээр нь ажилласан. Сум бүгд өөр өөрийн онцлогтой. Хөрсний нөхцөл тэр цаг уур бүгдээрээ өөр учраас сонголт бол байгаа юм байна лээ. Зүгээр тэрбумаасаа гаргах юм бол орон нутаг өөрсдөө тэрийгээ хариуцах шаардлага байгаа. Мөн одоо хариуцлагагүй гэж ярих юм уу энийг анх сонголт хийхдээ бол орон нутагт тэр газрын асуудлаа гаргаж өгөх дэд бүтэцтэй ойрхон байх гэдэг асуудлыг тавьж энэ сонгон шалгаруулалтыг бол хийсэн. Тэндээс бол нөгөө сумын газрын одоо газар зохион байгуулалттай холбоотойгоор байршил тавьснаас болоод зардал бол нэмэгдэж гараад байгаа юм байна лээ. Бид нар энэ үргэлжилж байгаа ажил дээр бол дэмжиж байгаа 91 таталцал дээр.

**Р.Сэддорж:** Ингээд 14 дэх санал хураалт явуулъя.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.1 дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.3”, “МУХТЖҮЧ 4.4.1”, “ЗГҮАХ 2.4.3.3” гэж, Төсөл, арга хэмжээ “1000 айлын орон сууцны хороолол”-ын гадна ус хангамж, ариутгах татуурга, гадна холбоо (Дорнод, Хэрлэн сум) гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,790.6” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,895.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт,

барилга, орон сууцжуулалтын яам” Хамтран хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

16.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.35”, “МУХТЖҮЧ 5.6.1.1”, “ЗГҮАХ 3.3.3.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Буйр нуур орчмын цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх (Дорнод, Халхгол сум) гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “978.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “978.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.3.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.3, 8.3.6”, “МУХТЖҮЧ 5.3.1.3”, “ЗГҮАХ 3.4.11” гэж, Төсөл, арга хэмжээ “Үр тарианы элеваторын барилга (Дорнод, Хэрлэн сум) гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “9,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

50 хувиас 50 хувийн санал авч санал дэмжигдсэнгүй.

18.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.35”, “МУХТЖҮЧ 5.6.1.1”, “ЗГҮАХ 3.3.3.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Хавирга хилийн боомтын өргөтгөлийн цахилгаан хангамж Хавирга 35 Кв ЦДАШ, 35/10 кВ-ын 2\*1600 Ква чадлын “Хавирга” дэд станц 35/10 кВ-ын “Хэрлэн” дэд станцын өргөтгөл (Дорнод) гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “10,402.7” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “5,201.3” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

19.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 8.1.2.5 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.45”, “МУХТЖҮЧ 5.4.1.2”, “ЗГҮАХ 3.3.5.9, 3.3.5.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Түүхэн аялал жуулчлалын хүрээнд “Чингис хааны Тугийн сүм”

цогцолбор байгуулах (Дорнод, Булган сум)” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,900.2” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “950.1” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

20.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.12, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.5” гэж, Төсөл, арга хэмжээ “Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Малчин сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “13,316.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “4,438.7” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Цэнгүүн гишүүн.

**С.Цэнгүүн:** Сангийн яамнаас тодруулж асуул асуух гэсэн юм. Энд зарчмын зөрүүтэй санал дээр.

Сангийн яаман дээр болохоороо Монгол Улсад нийт хэрэгтэй байгаа бүх одоо нөгөө сургуулийн шаардлагыг хэрэгцээ шаардлагыг яг тухайн хүүхдүүдтэй нь хамт тоон дээр статистик дээр тулгуурлаад гаргасан байгаа. Тэгэхээр яг Сангийн яаман дээр байгаа тооцооллоор энэ сумд энэ 320 хүүхдийн суудалтай сургууль яг хэрэгтэй байгаа юу? Сангийн яамнаас асууж байна.

**Р.Сэддорж:** Нэр, албан тушаалаа хэлээд 1 номер хариулаарай.

**Ж.Дэлгэржаргал:** Цэнгүүн гишүүний асуултад хариулья.

Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал.

Тэгэхээр яг манай хөрөнгө оруулалтын систем дээр бол бид нар яг хүн амынх нь одоо тоо хүүхдийн сургуулийн насны хүүхдийн тоо, өсөлт. Өсөлт нь жишээ нь бид нар Хансетаас авсан 2030 он хүртэлх өсөлтийнх нь прогноз дээр тулгуурлаад сургуулиудын хэрэгцээг бол гаргасан. Тэгээд 2028 он хүртэл Улсын хэмжээнд 2 ээлжээс дээш коэффициенттэй буюу шинээр сургууль барих хэрэгцээ бол 108. Нөгөө талд нь болохлоор ашиглалтын шаардлага хангахгүй нурааж барих хэрэгцээ бас 60 хэдэн төслийн хэрэгцээ байгаа. Тэгээд энэ хүрээндээ төлөвлөлт явж байгаа. Тэгээд Увс аймгийн Малчин сумын хувьд бол яг энэ хэрэгцээг нь би одоо систем дээр яг шалгаадахъя.

Яг тэр шаардлагад байгаа эсэхийг нь шалгаад танд эргээд хэлье.

**Р.Сэддорж:** Заяабал гишүүн.

**Б.Заяабал:** Баярлалаа. Тэгэхээр энэ дээр гишүүдээ нэг ийм юм яригдаад байна л даа. Өнөөдөр энэ хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан төслүүд энэ одоо жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр орж ирэх ёстой. Энэ одоо 6.10.1 дээр байгаа Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр энэ тэр гээд ингээд үйл ажиллагааны хөтөлбөр гээд бүх бодлогын баримт бичгүүдэд нь тусгагдчихсан асуудал, нэг.

Хоёрдугаарт нь нөгөө талдаа 6.10 дээр байгаа санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоо ТЭЗҮ зураг төсөв нь батлагдсан байх энэ тэр гэсэн энэ шаардлагууд нь бүрэн хангагдчихсан ийм төсөл 1 дүгээрт яг энэ төсөл.

Хоёрдугаарт нь, энэ одоо байгаа энэ 320 хүүхдийн сургууль нь 1982 онд ашиглалтад орчихсон, барилгын улсын байцаагчийн дүгнэлтээр одоо энэ сургуульд үйл ажиллагаа явуулах асуудалтай байна шүү, аюул учруулахуйц байна шүү гээд нэг ингээд барилгын Улсын байцаагчийн дүгнэлт нь гарчихсан. Ийм сургууль байгаад байгаа юм. Тэгээд манай Малчин сум бол 1-9 дүгээр ангийн хүүхдүүд сурдаг дунд сургууль, ахлах сургуульдаа өөр зэргэлдээ одоо сумандаа шилжиж сурдаг. Тэгээд сүүлийн жилүүдэд энэ сургуулиа дагаад бас энэ төвлөрлийн асуудал хүн амын асуудал бас ингээд хүүхдээ дагаад ингээд багасаад байдаг. Тэгээд хөдөө орон нутгийн зайлшгүй ийм зүйл ийм одоо сургуулиудыг хөдөө орон нутгийн одоо хөгжлийг дэмжих үүднээс зайлшгүй энийг тавьж өгөхөөс өөр одоо арга байхгүй ээ. Энэ юу нь бүүр зураг төсөв нь гарахаасаа гад гадна 2026 оны 5 сарын 7-ны өдрийн 798 тоот барилгын хөгжлийн дугаартай магадлалын дүгнэлтээр бас баталгаажчихсан байгаа, баталгаажчихсан байгаа. Тэгээд яг ийм төслүүдийгээ бид нар энд оруулахгүй юм бол Төсвийн тухай хуулийн нөгөө 29-ийн штрих 2.2 дээр байгаа шүү дээ.

Барилга байгууламжийн тухай хууль Барилгын тухай хуулийн зураг төсөв нь одоо сүүлийн 2 жилдээ хийгдсэн байж байж төсөв дээр тавигдана гээд.

Тэгээд одоо энэ хийгдчихсэн зураг төсөв нь хийгдчихсэн магадлалаар орчихсон энэ төсвүүдийгээ хийж чадахгүй бол 2 жил өнгөрчих юм бол ингээд шал хэрэггүй ингээд цаас болоод хувирчхаж байгаа юм. Яг ийм төслүүд нэлээдгүй байгаа л даа. Би хойшоо гарах болгонд нь би бас үгээ хэлье гэж ингэж бодож байгаа. Энэ төслийг бол дэмжихээс өөр аргагүй. Тэгээд ажлын хэсэг дэмжиж орж ирсэнд баярлалаа. Ингээд гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2.4, МУХТЖҮЧ-1.2.1.1, ЗГҮАХ-1.4.2.5, 2.3.1.1, 2.3.1.2, 2.3.1.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрүүл мэндийн төвийн барилга /Увс, Хяргас сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “30” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “6,350.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,116.7” гэж,

Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

22.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2, 6.4, МУХТЖҮЧ-4.4.1.2, ЗГҮАХ-2.4.3.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаангом сум доторх инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл хийх” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “125,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “12,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

44.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

23.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.2, ЗГҮАХ-3.3.2.24” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаангом-Наранбулаг чиглэлийн авто замаас Хар толгой-Тариалан сум чиглэлийн 20.7 км хатуу хучилттай авто зам /Увс, Тариалан сум/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “20” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “30,940.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “6,188.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 38.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

24.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-1.3.3.6” гэж, Төсөл, арга хэмжээ “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай 92.13 км авто зам барих /Орхон, Дархан-Уул, Төв/” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “150,034.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “11,139.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэлд “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.1, ЗГҮАХ-3.3.2.23” гэж, Төсөл, арга хэмжээнд “Жаргалант-Шинэ-Идэр-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “323,196.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт

сая.төг “96,958.80” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Уянга гишүүн асууя.

**Г.Уянгахишиг:** Энэ Сангийн яамнаас асууя тэгэх үү? Сангийн яам тэгээд ЗТЯ байгаа болбол асуумаар байх юм. Одоо энэ дээр байна шүү дээ үнийн дүн чинь тухайн жилд шаардагдах санхүүжилт чинь 96 тэрбум байгаад байна шүү дээ 96.9 тэрбум. Тэгээд энэ чинь өөрөө яг төсөвтөө ингэж орж чадах ажил юм уу эсвэл одоо томоороо угаасаа төлөвлөгөөнд чинь орчихсон байгаа юм уу? Энэ өөрөө нөгөө стратегийн хувьд жишээлбэл гишүүд болохоороо чухал буюу эрэмбээрээ өмнө гээд байгаа юм. Тэгэхээр эрэмбээ та хэд маань хийсэн юман дотор байхгүй байгаа юм уу? Энэ дээр нэг тайлбар авъя тэгэх үү?

**Р.Сэддорж:** Дэлгэржаргал нэг номер Сангийн яам. хариулъя.

**Ж.Дэлгэржаргал:** Гишүүний асуултад хариулъя Сангийн яам Дэлгэржаргал. Улсын жилийн төлөвлөгөө дээр бол ер нь яг нийт эх үүсвэр 15.3 их наяд байхаар өргөн барьсан. Энэ дотроо Улсын төсвийн эх үүсвэр нь 2.2 их наяд. Одоо 2026 онд манай явж байгаа хөрөнгө оруулалтуудын гэрээний зөвхөн гэрээний үлдэгдэл нь ирэх онд 3.6 их наяд байгаа. Энэ агуулгаараа одоо энэ жилийн төлөвлөгөө дээр байгаа эх үүсвэр өөрөө явж байгаа төслүүдээ бүрэн тавихад бол хүрэлцэхээргүй буюу энэ нь өөрөө шинэ хөрөнгө оруулалтын орон зай маш бага бараг байхгүй гэсэн үг. Яг энэ замынх нь хувьд бол яг аялал жуулчлалын трасс буюу аялал жуулчлалын хувьд бол яг шаардлагатай зам. Өнгөрсөн онд бол төсвийн төсөлд төлөвлөгдөж орж ирж байсан зураг төсөвтэй явж байсан. Энэ өндөр дүнгээрээ бид нар бол тусгахад бол маш хүндрэлтэй.

Дээрээс нь Төсвийн тухай хуулийн 29 дээр шинэ хөрөнгө оруулалтыг хамгийн ихдээ 3 хүртэлх жил буюу хэрэгжих хугацаа төсөвт өртгийн харьцаа тэнцүү хуваарилах ийм зарчимтай хуулийн заалттай. Өөрөөр хэлбэл бид нар одоо нэг жил гэвэл 100 хувиар 2 жил бол 50 хувиар, 3 жил хэрэгжүүлэх хамгийн дээд талын хугацаа гэхэд өртөг нь 100 тэрбум байлаа гэхэд санхүүжих дүн нь 30 тэрбумыг тусгах ийм харьцаатай явдаг.

Тэгэхээр яг энэ шаардлагуудаараа бас харах хэрэгтэй. Ер нь бол эх үүсвэрийн хувьд одоо ингээд төлөвлөгөө дээр батлагдлаа ч төсөв дээр тусгагдах боломж бол маш хязгаарлагдмал байгаа. Түрүүний Увсын сургуулийн хувьд бол би системээс харлаа. Малчин сумын хувьд бол 1982 онд ашиглалтад орсон барилга. 45 жил ашиглаж байгаа учраас нөгөө дахиж барих шаардлагатай төслийн жагсаалт бол байгаа юм байна аа.

**Р.Сэддорж:** Дэмжсэн зүйл ярилаа.

Цэнгүүн гишүүний асуултад хариулж байна. Цэнгүүн гишүүн хариулт авчав уу? Уянгахишиг гишүүн нэг минут.

**Г.Уянгахишиг:** Энэ дээр Сангийн яам Сангийн яам сая хариулахдаа одоо нөгөө ийм ийм байх ёстой энийг шалгах ёстой гээд байна. Тэгээд яг энэн дээр тэр шаардлага чинь хангачихсан юм уу, хангаагүй юм уу? Тэгэхээр бид нарт нэг ийм

асуулт байгаад байна шүү дээ. Хуульд нийцсэн юм уу нийцээгүй юм уу гэдэг эхний асуулт байна.

Дараагийнх нь төсөвт сууж чадах уу үгүй юу гэдэг нь 2 дахь асуудал байгаад байна тийм үү? Тэгэхээр яг энэ төслийн хувьд жишээлбэл яг ингээд бүх зураг төсөл магадлан энэ тэр нь байна. Тэгээд ингээд хуваарилалт нь өөрөө ямар байгаа юм бэ гэдэг дээр ингээд ойлгомжгүй хариулт өгөөд байхаар бид нар яаж шийдвэр гаргах вэ? Харин тийм. Хэрвээ төсвөө төсөл дээрээ хийнэ гэх юм бол энийг бид нар бүгдийг нь дэмжээд явахад асуудал байгаа юм уу гэдэг болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр та хэд өөрсдөө төлөвлөгөө дээрээ ингэж авчхаад энэ төлөвлөгөө чинь биелж чадахгүй болно биз дээ. Тэгэхээр тэрийгээ одоо энэ чинь тэгээд дандаа л батлагдаад л явбал л биелүүлэх ёстой болно шүү дээ. Тэгэхээр тэр тайлбараа жоохон тодорхой хэлээд өгөөч Сангийн яам.

**Р.Сэддорж:** Хариулах хүн байна уу 5 номер. Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Одоо шинэ нэмэлт эх үүсвэр гаргаад хөрөнгө оруулалт хийх орон зай байхгүй ээ. Сая Сангийн яам хэллээ шүү дээ. 3.6 их наядын гүйцэтгэл хүлээгдэж байна түүнээсээ бид нар нэг 2.2-ыг нь багтаах төсвийн орлогын чадавч байна аа. Урсгал зардлаа бид нар хэтрүүлээд нэмчихсэн байна аа. Хүрэхгүй, тэгэхээр энд энэ энд мянга батлаад энэ чинь төсөвт орох бололцоогүй байхгүй юу даа.

**Р.Сэддорж:** Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалт.

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

26.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “6.3.1.2 дахь дэд заалтын “Онги-Цагаанбургастай” төслийн бэлэн байдлын хангалт” гэсэн Шалгуур үзүүлэлтийн “Нийт санхүүжилтийн дүн сая төгрөг “0” гэснийг “44,490.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “0” гэснийг “30,230.0” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “5.7.1.2 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1, МУХТЖҮЧ-5.7.1.2, ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Дархан- Улаанбаатар чиглэлийн авто замаас Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн авто замын их засварын ажил” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “15,054.685” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “15,054.685” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Орон нутгийн төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ орон нутгийн төсөв юу вэ гэдгийг Сангийн яам хариулья. 5 номер.

**Ж.Энхбаяр:** Орон нутгийн төсөв рүү одоо ингэж орж бүр болохгүй. Энэ орон нутгийн төсвийг Их Хурал оролдоод байдаг. Ерөөсөө хуулийн зөрчил.

Хоёрдугаарт орон нутгийн төсөвт тавиад энэ төсвийг тэлсэнтэй холбоотойгоор нөгөө бид нарын алдагдал буюу гадаад зээлийн ашиглалт чинь тэр хэмжээгээр хорогдоод явчихна гэсэн үг. Сүүлдээ гадаад зээлийн ашиглалт ч байхгүй орон нутагтаа баахан тэлсэн төсвүүд баталчихсан. Тэгээд Их Хурал баталсан гэдэг ийм асуудалд орно шүү дээ. Сая тэр ТЭЗҮ нь гараагүй зураг төсөл нь батлагдаж байгаагүй юман дээр сая 40 хэдэн их наяд гээд л тэрбум гээд л тавьж байх юм. Тэр тоог хэнд тавиад байгаа юм, үндэслэл нь хаана байгаа юм. Материал нь үзсэн үү, үзээгүй шүү дээ. Ингэж болохгүй биз дээ энэ чинь. Одоо энэ чинь Монгол Улсын хөгжлийн бодлогын бичиг баримтыг та нар баталж байна шүү дээ. Тэгээд бүр сүүлдээ жиргээд цэцэрлэг, сургууль руугаа сумын түвшин рүүгээ ороод энэ чинь Эдийн засгийн байнгын хороо шүү дээ.

**Р.Сэддорж:** Хуулийн хүрээнд ажиллаж байна Энхбаяр сайд аа.

27 дээр санал хураалт гишүүд бэлдээрэй.

22.2 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

**Г.Очирбат:** Дараагийн санал.

28.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “4.4.4.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-7.3, МУХТЖҮЧ-4.4.4.1, ЗГҮАХ-1.1.4.4” гэж, Төсөл, арга хэмжээ “Төв аймгийн Баянчандмань сумын Дархан-Эрдэнэтийн зам дээр гүүрэн зам тавих” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, “Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,100.0” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,100.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Асуух асуулттай гишүүд байхгүй юу? Санал хураалт.

Ажлын хэсгийн дэд дарга тайлбарлая.

**Н.Наранбаатар:** Энэ саналыг Эрдэнэболд гишүүн зарчмын зөрүүтэй саналаар гаргасан юм. Тэгээд энэ Дарханы зам сумын дундуур яваад байгаа шүү дээ. Тийм энэ Баянчандмань сумын дундуур явж байгаа юм. Тэгээд аваар осол их гараад байдаг юм байна лээ. Тэгээд тэрний дээгүүр ийм явган хүний гүүрэн байгууламж л хийх ийм юу байгаа. Тэр аваар ослын тоос судалгаа бүх юмнууд нь гишүүн дээр өөр дээр нь байгаа.

**Г.Уянгахишиг:** Зураг төсөлтэй юм болов уу?

**Н.Наранбаатар:** Зураг төсөлтэй, шаардлага хангаад л орж ирсэн.

**Г.Очирбат:** 28 дээр санал хураалт гишүүд бэлдээрэй.

Санал хураалт.

33.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

29.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1”, “МУХТЖҮЧ-5.7.1.1”, “ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 87.9 км” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “45” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “92.31 тэрбум төгрөг” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “92.31 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Гишүүд бэлдээрэй.

Санал хураалт.

Ажлын хэсгийн дэд дарга Наранбаатар гишүүнд микрофон өгье.

**Н.Наранбаатар:** Үгүй энэ чинь орон нутгийн зам биш л дээ. Энэ чинь Улсын чанартай Улсын чанартай авто зам байгаа юм. Тэгээд энэ чинь бол ер нь бол Монгол Улсын эдийн засгийн судас шүү дээ. Одоо бүх л уул уурхай бүх төслүүд хил боомт руу явж байгаа замын засвар. Энэ зам эвдэрснээс болоод маш олон аваар осол одоо олон зүйлүүд гарсан байгаа. Мөнхбат гишүүн оруулсан санал байгаа юм.

**Р.Сэддорж:** Санал хураалт. Батчимэг гишүүн горимын санал гаргаж байна.

**П.Батчимэг:** Сая харин санал өгөх гэсэн чинь төхөөрөмж юу яачихлаа. Тэгээд энэ саналыг дахин хураалгаж өгөх үү? Хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгөөч.

**Р.Сэддорж:** Батчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулья.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд 29 дүгээр саналыг саяын санал хураалт хүчингүй болсон тул дахин санал хураалт явуулья гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт.

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-8.1.1”, “МУХТЖҮЧ-5.7.1.1”, “ЗГҮАХ-3.3.2.16” гэж, Төсөл, арга хэмжээ “Чойр-Мандалговь-Арвайхээрийн чиглэлийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “230.98 тэрбум төгрөг” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “105.0 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.3 дахь дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.39”, “МУХТЖҮЧ-5.6.1.3”, “ЗГҮАХ-1.1.2.10” гэж, Төсөл, арга хэмжээ “Дорноговь аймгийн Айраг сумын 8 МВт хүчин чадалтай дулааны зуух барих, шугам сүлжээ өргөтгөх” гэж, Шалгуур үзүүлэлт “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “8,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “8,800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагчид “Хот байгуулат, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

32.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.3.3 дахь дэд заалтын “Гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах ажиллагаанд хүнгүй техник хэрэгслийг нэвтрүүлэх” гэсэн Төсөл, арга хэмжээний Суурь он 2025 гэснийг “2024” гэж, Суурь түвшин “102” гэснийг “10” гэж, Зорилтот түвшин “112” гэснийг “20” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,650.0” гэснийг “3,300.0” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар саяын 32 дахь санал дэмжигдлээ.

33.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 5.1.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-4.2.14”, “МУХТЖҮЧ-5.1.1.1”, “ЗГҮАХ-3.3.1.13” гэж, Төсөл, арга хэмжээ “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр” гэж, Шалгуур үзүүлэлт “Нүүрснээс үйлдвэрлэх шатахуун, хийн түлшний дотоодын хэрэглээнд эзлэх хувь хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “10” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “75,645.70” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “7,564.57” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагчид “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж, Хамтран хариуцагч “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Аж үйлдвэрийн яамнаас асууя. Нөгөө төрийн нарийн нь байсан уу? Сайд нь байхгүй төрийн нарийн нь байхгүй хааччихсан юм энэ чинь. Ням-Очир төрийн нарийн суугаад байдаг. Энийг тэр нөгөө Аж үйлдвэрийн яамнаас тайлбарлуулъя. Баатархүү тайлбарыг нь аваадахъя. Эхлээд тэр яамны төрийн нарийнаа дууд л даа. Боловсролын яамны төрийн нарийн байгаад байдаг. Бүгдийг нь тэгээд хасах юм уу?

**Р.Сэддорж:** Хариулах хүн байна уу?

Санал хураалт.

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

34.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 6.2.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.5.8”, “МУХТЖҮЧ-6.2.2.1”, “ЗГҮАХ-3.3.3.6, 3.3.3.9, 3.3.3.12” гэж, Төсөл, арга хэмжээ “10,000 нарны дээвэр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Хөтөлбөрт хамрагдсан өрх” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “3000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “298,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “89,400.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрчим хүчний яам” гэж, Хамтран хариуцагч “Эрчим хүчний зохицуулах хороо” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Энэ саналыг бас гаргасан юм аа. Энэ 10 мянган нарны дээвэр гээд. АН-ын мөрийн хөтөлбөрт байдаг. Ардын намынхны бас мөрийн хөтөлбөрт байдаг. Ер нь одоо эрчим хүчний салбар бол Монгол Улсад өөрөө хамгийн одоо тулгамдсан салбар болчихоод байгаа. Энэтэй холбоотойгоор 2027 оны хөгжлийн төлөвлөгөө дээр бол энэ 10 мянган нарны дээврийг оруулж ирээд 2027 ондоо бол 3 мянган ширхгийг буюу 21 аймгийн 9 дүүрэг, дүүрэг болгоноос, нэг хороо, аймаг болгоноос, нэг сумыг сонгоод ялангуяа хил орчмын аймгийн сумдуудыг сонгоод ингээд Монгол Улсын Засгийн газрын барьж байгаа бодлого, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нийцэж байгаа.

Мөн дээрээс нь Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд орчихсон явж байгаа. Үндсэндээ бол энэ бол та бүхэн мэдэж байгаа. Эдийн засгийн байнгын хорооноос 2 удаагийн сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар руу чиглэл өгөх төслийг тогтоолын төсөл баталж, чиглэл өгсөн байгаа. Ингээд үүнтэй холбоотойгоор энэ санал орж ирж байгаа. Тэгээд Эдийн засгийн байнгын хорооны гишүүд минь энэ саналыг дэмжиж өгөөрэй.

Энэ саналыг дэмжсэнээрээ 21 аймаг, 9 дүүрэг мөн дээрээс нь иргэд маань 20 хүртэл киловаттын эрчим хүчийг өөрөө үйлдвэрлээд өөрөө өөрийнхөө хэрэглээг хангаад зардлаа хэмнээд мөн дээрээс нь төвийн сүлжээнд нийлүүлж бусад нийтийн сайн сайхны төлөө бас ийм үйл хэрэг болох юм байгаа юм шүү. Тэгээд та бүхэн дэмжиж өгөөрэй гэж хүсье ээ. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.6.1.дэх заалтад Хөтөлбөрийн үр дүн “Хүний эрхийн боловсрол, судалгаа шинжилгээний бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-5.5, 5.1.8”, “МУХТЖҮЧ-7.6.1”, “ЗГҮАХ-4.1.1.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын бүс нутгийн сургалт, судалгааны төв байгуулах” гэж, Шалгуур үзүүлэлт “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2027” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “900.0” гэж, Тухайн жилд

шаардагдах санхүүжилт сая.төг “900.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Гадаад харилцааны яам” гэж, Хамтран хариуцагч “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.26, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “6-9 дүгээр ангийн нийт 263808 хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулах /хичээлэх хоног 180 нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 3500₮/” гэж, Шалгуур үзүүлэлт “6-9 дүгээр ангийн сурагчдын үдийн хоолонд хамрагдалт” Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “228,300.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “228,300.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ 2 санал адилхан учраас нэг унших юм байна.

37.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.14, 2.1.26, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад шим тэжээллэг хоолны үйлчилгээг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт “Дунд ангийн /6-9 дүгээр анги/ нэг суралцагчийн сургуулийн хоолны үйлчилгээний санхүүжилтийн хэмжээ” гэж, Хэмжих нэгж “Төгрөг” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “4000 төгрөг” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “191,152.8” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “191,152.8” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Сангийн яам гэж нэмэх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал.

Ингээд анхаараарай 36 дахь саналаар санал хураалт явуулна.

Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Боловсролын яамнаас асуугаадахъя. Одоо энэ үдийн хоолны хөтөлбөрийн байгаа байдлын талаар нэг мэдээлэл өгөөдхөөч.

**Р.Сэддорж:** Мэдээлэл нэг номер өөрийгөө танилцуулаад.

**Т.Ням-Очир:** Боловсролын яамны ТНБД Ням-Очир Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Одоогоор бол бага боловсролын 1-ээс 5 дугаар ангийн 400 гаруй мянган хүүхэд өдөрт 2500 төгрөгөөр үдийн хоолонд хамрагдаж байгаа. Энэ хамрагдаж байгаа өртөг бол мэдээж одоо нэг хүүхэд өдөрт авах шим тэжээлийнхээ 35 хувийг үдийн хоолноос авах ёстой. Тэгээд одоогийн байдлаар бол энэ 2500 төгрөг бол 70 орчим хувийг л хангаж байгаа гэсэн ийм тооцоо судалгааг судлаачид гаргадаг. Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хууль 2019 онд батлагдсан.

Энэ хуулиар бол дунд, ахлах ангийн хүүхдүүдийг бас үе шаттайгаар хамруулахаар батлагдсан боловчиг өнөөдрийг хүртэл бас дунд, ахлах ангийн хүүхдүүдийг эдийн засгийн нөхцөл байдал төсөв санхүүгээс хамаараад одоо үдийн хоол хөтөлбөрт хамруулж чадаагүй ийм нөхцөл байдалтай байгаа.

Одоо бол 400 гаруй мянган хүүхдэд одоо жилдээ 170 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт гардаг.

Ер нь хүүхдийн өсөлт хөгжилт эрүүл мэндэд бол хамгийн суурь үзүүлэлт бол энэ үдийн хоолны хөтөлбөр. Тийм учраас энэ бол үр дүн гарах хөтөлбөр.

**Р.Сэддорж:** Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Тэгэхлээр энэ хүүхдүүд өдрийн хоол идсэнээр бие бялдрын хөгжил болоод олон чухал үр дүнгүүд гарч байгаа талаар Боловсролын яамны ТНБД хэллээ. Тэгэхээр одоо бид нар бол хүүхдүүдээсээ мөнгө харамлаж болохгүй. Одоо Байнгын хорооны гишүүд байна. Энэ хүүхдийн үдийн хоол хөтөлбөрийг бүгдээрээ дэмжицгээе гэж санал хэлж байна аа.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Батчимэг гишүүн асуулт асууна.

**П.Батчимэг:** Боловсролын яамны ТНБД-аас асууя.

Үдийн хоолны одоо энэ хүүхдийн үдийн хоолны хөтөлбөрийг бол дэмжилгүй яах вэ. Гэхдээ энэ яг үдийн хоол бэлтгэдэг тэр газар энэ сургууль дээр энэ тэр тэр орчин байж байгаа газар нь маш арчаагүй аягүй муу байдаг юм байна лээ. Энэ тал дээр одоо Боловсролын яам ямар арга хэмжээ авдаг юм. Ер нь яадаг юм бол? Өвөл нь ингээд бараг тогооч тэр бэлтгэгч нар, туслах бэлтгэгч нар нь би нүүрээ бараг харж чаддаггүй тийм цан цохидог ийм байдалтай. Тэгээд нуль нөгөө хөгц болчихсон тийм байранд тэгээд хүүхдийн хоол хийгээд гар мараа одоо хаана угааж байгаа нь ч тодорхойгүй. Сая Өвөрхангай аймгийн Хужирт сум, Хайрхандулаанд очиж үзэхэд яг адилхан тийм нөхцөл байдал байна шүү дээ. Энэ тал дээр та нэг хариулаад өгөөч.

**Р.Сэддорж:** Нэг номер маш тодорхой хариул.

**Т.Ням-Очир:** Нийт ерөнхий боловсролын сургуулиудын 67 хувь нь л яг стандартын шаардлага хангасан гал тогоотой гэдэг ийм тооцоо судалгаа байдаг. Өөрөөр хэлбэл хуучны барилгууд дээр яг энэ хүүхэд бүхэнд үдийн хоолоор үйлчлэх яг танхим олон хүүхдэд хоолоор үйлчлэх энэ стандарт нь байхгүй учраас одоо шинээр одоо хийгдэж байгаа барилгын зураг төсөв дээр нь хооллох танхимтай яг сургуулийнх нь хүчин чадалд таарсан ийм. Одоо бэлтгэх, үйлдвэрлэх, түгээх ийм байхаар ингэж одоо зохицуулалтаа хийж явж байгаа.

2019 онд хоол үйлдвэрлэл үйлчилгээний хуулийг хэрэгжүүлж эхлэхэд ер нь бол аймгийн төв нийслэлийн сургуулиуд бол бараг шахуу 100 хувь түрээсийн гал тогоотой байсан. Хоол үйлдвэрлэлийн хууль батлагдсанаараа хоол бэлтгэлийг сургууль дээр явуулах болсноор тоног төхөөрөмжийн хангалт, хүний нөөцийн хангалт, хүний нөөцийг сургаж бэлтгэх асуудлууд дээр бол үе шаттай сайжруулалтууд хийгдээд явж байгаа. Одоо бол бид нар яг сургуулийн хоол бэлтгэдэг хүний нөөцийг бэлтгэдэг шим тэжээл арга зүйн төвийг бол байгуулсан.

Салбар дундын ажлыг уялдуулсан ажлын удирдамж жишиг одоо менютэй болсон гээд ингээд ажлууд бол үе шаттай сайжраад явж байгаа.

Тэгээд тодорхой хугацааны дараа бол бүх барилга байгууламжууд дээр бол энэ шинэчлэлүүд хийгдээд явах бүрэн боломжтой гэж харж байгаа.

**Р.Сэддорж:** Батчимэг гишүүн тодруулж асууна.

**Т.Ням-Очир:** Бусдаар бол яах вэ таны ярьж байгааг ойлгож байна. Ганцхан миний яриад байгаа тэр байр савны асуудал хоол бэлтгэж байгаа тэр газрын ариун цэвэр тэр юу чинь ерөөсөө шаардлага хангахгүй байгаа шүү дээ. Тэгээд тэрэн дээр одоо ямар арга хэмжээ авах юм бэ гээд байгаа юм. Тийм хөгц цохисон байранд тэгээд байгаад байх юм уу? Гараа угаадаг газар байхгүй тийм муу нөхцөлд одоо энэ хүүхдийн үдийн хоол бэлтгэх юм уу.

**Р.Сэддорж:** Тодорхой хариулаарай нэг номер.

**Т.Ням-Очир:** Мэдээж энэ орчин нөхцөл дээр бол салбарын хяналтын байгууллагууд хяналтаа тавиулаад явж байгаа. Хэрвээ яг ийм шаардлага хангахгүй байвал засвар үйлчилгээ бол хийх ёстой. Одоо бол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Сургуулийн өмнөх ерөнхий боловсролын хуулиар орон нутгийн соёл, спорт, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын засвар үйлчилгээ бол орон нутаг өөрөө төсвөөрөө хариуцаад ингээд засвар үйлчилгээ хийгээд явдаг.

Хэрвээ яг ийм тодорхой кэйс байвал орон нутаг дээр нь бид нар шаардлагаа тавиад засвар үйлчилгээ хийлгүүлэхээр явах боломжтой.

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

**Д.Үүрийнтуяа:** 2 асуулт байна.

Нэгдүгээрт хүүхдийн хоол, хоолны зардал, нэгжийн зардлыг нэмээд тавьдаг. Яг таваг дээр тэр нэмсэн зардлаар хоолны чанар, калори, авах ёстой илчлэгийг нэмж чадаж байна уу үгүй юу гэдэг дээр ер нь яаж хяналт хийж байна. Боловсролын яам 1 дүгээрт.

Хоёрдугаарт, ер нь бол хүүхдийг халуун хоол үйлдвэрлэлийг яг дэргэд нь халуун хоолоо үйлдвэрлээд л өгье гэж байгаа шүү дээ. Энд бол юу гэдэг юм гал тогоонд ингээд нэг аймаар олон ажилтан аваад л, баахан туслах бэлтгэгч аваад л хоол үйлдвэрлэдэг бараг хоолны газрын хэмжээний боловсролын байгууллага болж өөрчлөгдөх нь гэдэг концепцыг зарим хүмүүс яриад байна лээ л дээ. Үндсэндээ бол бэлэн бүтээгдэхүүнийг одоо халуун хоол бэлтгэхэд шаардлагатай түүхий эдийг боловсруулж бэлтгээд, тэр бэлтгэсэн бүтээгдэхүүнийг нийлүүлээд түүнийгээ бол яг халуун хоол болгоод л газар дээр нь хүүхдүүдэд өгөх боломжтой энэ концепцыг хэрэгжүүлнэ гэж ойлгож байгаа шүү дээ.

Тэгэхээр энэн дээр та илүү тэр одоо ойлголтыг бас тодорхой болгож өгөх шаардлага байгаад байна л даа. Энэ дээр боловсролын яг ямар бодлого бариад байна. Хяналтыг яаж хэрэгжүүлэх гэж байна?

**Р.Сэддорж:** Нэг номер тодорхой хариулъя.

**Т.Ням-Очир:** Яг тийм. Үүрийнтуяа гишүүний хэлж байгаагаар яг сургууль дээр бид нар халуун үйлдвэрлэлээ буюу зөвхөн одоо нөгөө хагас одоо бэлдээд ирчихсэн жишээлбэл хэрчсэн төмс, хэрчсэн лууван, яг тухайн одоо хоолонд нь зориулсан махнуудыг шууд захиалж авдаг. Сургууль дээр зөвхөн халуун үйлдвэрлэл явдаг. Магадгүй дунд, ахлах ангийнхыг нэмэгдсэнээр сургууль дээрх хүний нөөц нэмэгдэнэ гэдэг ч юм уу тэр асуудлуудыг бид нар аль болох зайлсхийж тэр үйлчилгээгээ илүү авто сорсинг хийж хувийн хэвшлээр ханган нийлүүлэх үйлчилгээгээ илүү хувийн хэвшлээр хийлгэж ингэж явах ийм одоо зарчмын одоо бодлогын өөрчлөлтүүдийг бол хийхээр бэлтгэл ажил, зохион байгуулалт бүх зүйлүүд дээр бол бас анхаараад энэ дээр бол одоо төлөвлөлт хийгээд явж байгаа.

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн тодруулна нэг минут.

**Д.Үүрийнтуяа:** Тэгэхээр хүүхдийн хоолны чанар гэдэг зүйл дээр бол онцгой анхаарах хэрэгтэй. Бид яг энэ хүүхдүүдэд яг энэ өсөж байгаа эрүүл иргэн болж төлөвших энэ боломжтой цаг хугацаанд нь илчлэг калкалорийн одоо стандартын дагуу олгоогүйгээс болоод насан туршийн өвчтэй иргэдийг бий болгоод байгаа юм Монголчууд. Өнөөдөр хүүхдийнхээ тавагтай хоолноос бид нар төсөв хасахдаа биш. Харин хүүхдэд илүү илчлэгтэй калоритой хоол өгөх тэр боломжийг харах ёстой. Өнөөдөр хоол идэхийн тулд сургууль дээрээ ирж байгаа олон мянган хүүхдүүд байгаа шүү цаана чинь. Тийм учраас энэ 500 тэрбум төгрөг гэж одоо дараагийн 36, 37 хоёр нийлээд одоо сургуулийн хүүхэдтэй холбоотой, хоолтой холбоотой асуудал. Хэдий 500 тэрбум төгрөгийн асуудал яригдаж байгаа юм шиг боловчиг эргээд энэ өөрөө ЖДҮ-лэлээ дэмжиж байгаа юм. Сургууль болгон саяын хэлдгээр бэлэн бүтээгдэхүүнээ худалдаж авахад тэнд олон үйлдвэрлэгчдийг дэмжих боломж юм энэ талаас нь хараасай гэж хүсэж байна.

**Р.Сэддорж:** Баярлалаа та бүхэнд. Ингээд гишүүд байрлалаа эзэлье.

Санал хураалт.

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Ингээд 37 дугаар санал 36-даа орчихсон багтчихсан учраас хураахгүй юм байна. Сая бол бид 6-9 дүгээр анги дунд анги билүү. Одоо ингээд ахлах анги буюу 10-12 дугаар ангийн.

38.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.26, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.1.15” гэж, Төсөл, арга хэмжээ “10-12 дугаар ангийн нийт 134491 хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулах /хичээлэх хоног 185 нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 4000₮/” гэж, Шалгуур үзүүлэлт “10-12 дугаар ангийн сурагчдын үдийн хоолонд хамрагдалт” Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2026” гэж, Суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “128,800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “128,800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж, Хамтран хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны гишүүд Монгол Улсын нийт хүүхдийг алагчлалгүйгээр 6-12 дугаар ангид одоо хоол идэхгүй байгаа хүүхдүүдэд үдийн цайг нь бага ч гэсэн одоо 3500-4 мянган төгрөгөөр олгохыг дэмжиж Улсын Их Хурлын чуулганд оруулж байна аа. Тэгээд энэ шийдвэрийг гаргасан Эдийн засгийн байнгын хорооны нийт гишүүддээ Монгол Улсын боловсролын одоо тогтолцоо болон нийт хүүхдүүдийн эцэг эхчүүдийнхээ өмнөөс баярлаж талархаж байгаагаа илэрхийлье.

Тэгээд зөвшөөрлийг нь олгочход бол арга нь олддог юм билээ. Тийм туршлагауд бас байдаг юм билээ аймгуудаас. Зөвшөөрлийг нь олгочихвол энэ хүүхдийн хоолыг бол дүүргийн дарга, хорооны дарга нар, сургуулийн захирлууд хариуцна. Аймгийн дарга нар хариуцна, сумдын дарга нар хариуцна, сургуулийн захирлууд хариуцна. Тэгээд хүүхдүүддээ хооллохгоод бараг энэ дүүргийнхээ хүүхдийг хооллохгоод дүүргийн дарга бас хоолонд орох. Ингэж байж бас юм сайхан шударга явах байх. Тэгээд Монгол даяар энэ одоо үйл явдал бол хамгийн хэрэгтэй зүйл ээ. Тэгээд дараа дараагийн тэр Батчимэг гишүүнээ сайжруулах одоо хоолны заалан дээрээ анхаарах илүү одоо боловсронгуй болгох хоол. Үйлдвэрүүд их дэмжигдэх байх. Төсөв хэдий бага ч гэсэн Үүрийнтуяа гишүүн бас энэ дээр сая санал хэллээ. Тэгээд та бүхэнд баярлалаа.

39.Төслийн 2 дугаар хавсралтын “5.7.1.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.10”, “МУХТЖҮЧ-1.1.2.1”, “ЗГҮАХ-2.2.2.1.4, 2.2.2.1.” гэж, Төсөл, арга хэмжээ “Сурагчийн 59 дүгээр гудамжнаас 47 дугаар гудамж хуртэлх авто зам гүүрний ажил авто замын их засварын ажил” гэж, Шалгуур үзүүлэлт “Ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “6” гэж, Зорилтот түвшин “8” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,650.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,650.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Зам, тээврийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.13, МУХТЖҮЧ-6.3.1.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Сургалтын STEAM боловсролын хэрэглэгдэхүүн” гэж, Шалгуур үзүүлэлт “Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь” гэж, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “10” гэж, Зорилтот түвшин “16” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “2,000.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “2,000.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Боловсролын яамнаас нэг хариу авъя тайлбар авъя.

**Т.Ням-Очир:** Боловсролын яамны ТНБД Ням-Очир.

2019 онд Дэлхийн банкны бага боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд бага боловсролын нийт одоо боловсрол бага боловсролын сургалт үйл

ажиллагаатай нийт сургуулиудад системийн 1, 1 анги танхимыг бол 2019 онд тохижуулж өгсөн байдаг. 2021 онд мөн тус төслийнхөө хүрээнд нэг одоо сэлбэн сайжруулалт хийсэн. Тэгэхээр системтэй холбоотой бол одоо түүнээс хойш одоо яг тусгайлсан улсын төсвөөр одоо сэлгэлт сайжруулалт бол хийгдээгүй байгаа.

Ингээд 50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

41.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.1.37, МУХТЖҮЧ-1.1.2.1, ЗГҮАХ-2.2.2.1” гэж, Төсөл, арга хэмжээ “Чингэлтэй дүүргийн нэг сургуулийг Кембирджийн хөтөлбөртэй болгох” гэж, Шалгуур үзүүлэлт Стандартын техник зохицуулалтын шаардлага хангасан ерөнхий боловсролын эзлэх хувь, Хэмжих нэгж “Тоо” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “4” гэж, Зорилтот түвшин “6” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “1,500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “1,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Цэнгүүн гишүүн горимын санал гаргая гэж байна.

**С.Цэнгүүн:** Саяын санал хураалтад оролцож амжсангүй. Санал хураалтыг дахин явуулахыг хүсье.

**Р.Сэддорж:** Ингээд 50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

42.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.3.1 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-3.3.3, МУХТЖҮЧ-2.1.4.1, ЗГҮАХ-2.1.3.12” гэж, Төсөл, арга хэмжээ “Чингэлтэй дүүргийн ЖДҮ үйлдвэрлэл эрхлэгч нарт тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт Хамрагдсан өрх, гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2025” гэж, Суурь түвшин “1259” Зорилтот түвшин “3000” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “800.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “800.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

43.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.3 дэх дэд заалтад Бодлогын үндэслэл “АХ-2.2, МУХТЖҮЧ-1.2.1.1, ЗГҮАХ-2.3.1.3” гэж, Төсөл, арга хэмжээ “Чингэлтэй дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх” гэж, Шалгуур үзүүлэлт Хорт хавдрын эрт илэрүүлэг, үзлэгт хамрагдсан хүн ам” гэж, Хэмжих нэгж “Хувь” гэж, Суурь он “2024” гэж, Суурь түвшин “65” гэж, Зорилтот түвшин “66.5” гэж, Нийт санхүүжилтийн дүн сая.төг “500.0” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг “500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэр “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Баатархүү гишүүн.

Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүдийг ирцэд ортол түр завсарлаадахъя. 30 минут хурал түр завсарлая. Завсарлаж байна.

Байнгын хорооны санал хураалтад ирц хүрэхгүй байгаа тул хойшлуулж байна. Маргааш өглөө 9 цагаас мөн Ерөнхий сайд Засгийн газраас сайдуудыг байлгах шаардлагатай байна. Өнөөдөр чинь бараг 3 сайд л байсан. Бусад сайдуудыг байлгая. Ингээд маргааш өглөө 9 цагаас Байнгын хорооны хуралдаан үргэлжилнэ ээ.

18.37 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА